



Оюу толгой

Эрт, эдүгээ, ирээдүй

Хураангуй хувилбар
2018 он VIII сар

Энэхүү тайлангийн тухай

Энэхүү тайланг хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, бэхжүүлэх зорилгоор компани, хөгжлийн агентлаг төдийгүй Засгийн газруудад бодлогын болон стратегийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Эрго стратеги” групп бэлтгэв. Тус групп нь уул уурхайн олборлох салбар болон бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн чиглэлээр мэргэшсэн бөгөөд харилцагчийн нөхцөл байдлыг үнэлэх, боломж болон эрсдэлийг нь судлан зөв шийдвэр гаргахад туслах, төсөл хэрэгжүүлэх чадамжийг нь хөгжүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг. “Эрго стратеги групп” өнөөдөр Лондон, Брисбан, Лима дахь салбаруудаараа дамжуулан дэлхийн зургаан тивийг дамнан үйл ажиллагаа явуулж байна.

Тайланд орсон мэдээллүүд нь тайлан хэвлэгдэх үеийн хамгийн шинэ, найдвартай эх сурвалжид түшиглэсэн бөгөөд үндсэн мэдээллийг “Оюу толгой” компаниас авсан болно. Тэрчлэн, Монгол Улстай холбоотой бүх мэдээллийг албан эх сурвалжаас авав. “Эрго стратеги” группээс мэргэжлийн дүн шинжилгээ хийсэн уул уурхай болон эдийн засгийн загварчлалууд нь ирээдүйн таамаг, хэтийн төсөөлөл дээр тулгуурласан тул тайланд дурдаж буй ирээдүйн тоо баримтууд нь бодит байдал дээр яв цав биелэхгүй байж болохыг хэлэх нь зүйтэй.

Оршил

Өнө эртнээс нааш зөвхөн хөдөө аж ахуй эрхэлж ирсэн Монгол Улс өргөн цар хүрээтэй аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлснээр эдийн засгийн томоохон шинэчлэл хийж байна. Энэ шинэчлэлийг амжилттай хийснээр Монгол Улсын эдийн засаг хөгжлийн дараагийн шатанд дэвших учиртай. Хараахан бүрэн дүүрэн ашиглагдаагүй байгалийн арвин баялаг нь хөгжлийн шинэ боломж нээхийн сацуу эдийн засгийн шилжилтийг хурдасгаж, Монголын ирээдүйн амжилт, ололтыг санхүүжүүлнэ. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд Монголын говьд уул уурхайн хөрөнгө оруулалтын томоохон, цоо шинэ үе эхэлсэн юм. Эдгээрээс хамгийн том төдийгүй бэлгэ тэмдэг болсон төсөл нь “Оюу толгой”. Өдгөө тус компани Монгол Улсын хамгийн том татвар төлөгч болсон бөгөөд энэ төслийн эдийн засагт үзүүлж буй үр нөлөө хаанаас нь ч харсан илэрхий байна.

Ийм өргөн цар хүрээг хамарч байгаа “Оюу толгой” олон нийтийн анхаарлын төвд аяндаа орж ирсэн юм. Олон үе шаттай хэрэгжих хөрөнгө оруулалт, тэдгээртэй холбогдох гэрээ хэлэлцээрүүд, техникийн болоод санхүүгийн нарийн төвөгтэй байдал, урт удаан үргэлжлэх бүтээн байгуулалт зэрэг онцлог шинж нь үнэнээс худлыг ялгаж, буруу ойлголтыг залруулахад тус болсонгүй. Тиймээс энэ тайлангаар “Оюу толгой” төслийн хөрөнгө оруулалтын талаарх хамгийн чухал мэдээллийг энгийн үг хэллэгээр нэг баримт бичигт нэгтгэж сонирхогч талуудад мэдээлэл болгон хүргэхийг зорьсон юм. Мөн төслийн өртөг болон өгөөжийн хуваарилалтын урьдчилсан таамаглал, эл аварга уурхайн олборлолт, боловсруулалт, борлуулалтаас гарах бодит үр өгөөж, боломж болон эрсдэлийг харуулахыг зорилоо.

“ОЮУ ТОЛГОЙ”

Энэхүү тайланг хэрхэн ашиглах вэ?

Энэхүү тайлан нь дөрвөн бүлэгтэй. Энэхүү интерактив Агуулгын хүснэгтийг ашиглан өөрийн сонирхсон сэдвийг сонгох боломжтой .


Зургийг томруулах буюу татаж авах бол Татаж авах гэсэн дүрсэн дээр дарна уу  .

1

Нэгдүгээр хэсэгт социализмын үеэс хойших Монгол Улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын тухай өгүүлнэ. Үүнд, эдийн засгийн өнөөгийн байдал болон ирээдүйн төлөвийн салшгүй суурь болсон уул уурхайн салбарын үр нөлөө, ач холбогдлыг онцолж, голлох үзүүлэлтүүдийг нь тайлбарлана. Үнэ цэнэ нь дэлхийн зах зээл дээр тодорхойлогддог тус салбарын хөрөнгө оруулалтад нөлөөлөх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийг мөн авч үзнэ.



Хуудас 8. Уул уурхайг түшиглэсэн хөгжил



Хуудас 11. Нүсэр төслийн үе шаттай санхүүжилт

2

Хоёрдугаар хэсэгт хувь нийлүүлэгчдийн бүтэц, үндсэн гэрээнүүд, ил болон гүний уурхайн бүтээн байгуулалт, ашиглалт, баяжуулах үйлдвэр, эдгээрийг бүтээн байгуулах өртөг зардал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах, түүнтэй холбоотой санхүүжилтийн бүтэц зэрэг “Оюу толгой” төслийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдийг цогцоор нь шинжилнэ.



Хуудас 31. Эхний бүтээн байгуулалт төлөвлөсөн хуваариас өмнө дуусав



Хуудас 35. Олон улсын нэр хүндтэй санхүүжүүлэгчдийн итгэлийг олов.

Дэлгэмэл инфографик

Та энэ тайлангаас доорх сэдвүүдийг агуулсан дэлгэрэнгүй инфографиктай танилцах болно.



ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Сэргээгдэх эрчим
хүчний хувьсгалын
түлхүүр

Хуудас 12



ҮНДСЭН ГЭРЭЭНҮҮД

“Оюу толгой”-н
бүтээн байгуулалтын
түүхэн товчоон

Хуудас 20



ХҮДРЭЭС МЕТАЛ

“Оюу толгой”-н
зэсийн
үйлдвэрлэл

Хуудас 28



САНХҮҮЖИЛТ, МӨНГӨН УРСГАЛ

Хөрөнгө оруулалт,
зэс олборлолт,
мөнгөний урсгал

Хуудас 36



ӨГӨӨЖ ХУВААРИЛАЛТ

Монгол Улсад нэмүү
үнэ цэнэ үүсэх нь

Хуудас 42



ХҮЧИРХЭГ ЭДИЙН ЗАСАГ


Бусдаас
суралцах

Хуудас 60

3


4

Гуравдугаар хэсэгт төслийн эдийн засгийн үр нөлөөг авч үзнэ. Энд Монгол Улсын Засгийн газар болон хөрөнгө оруулагчдын хооронд мөнгөн урсгалын хуваарилалтыг харууллаа. Олон нийтийн анхаарал зөвхөн энэ хуваарилалтад л төвлөрдөг байдлыг залруулах үүднээс “Оюу толгой”-н нийгэм, эдийн засагт үзүүлэх шууд, шууд бус болон дам ач холбогдлыг илүү өргөн хүрээнд харуулна. Үүний тулд мөнгөн урсгалын шинжилгээг нийгэм, эдийн засгийн үнэлгээний бусад аргуудтай хослуулан судалж, төслийн өгөөжийг тайлбарлана.




Хуудас 46. Үе дамнан хүртэх өгөөж


Сүүлчийн дөрөвдүгээр хэсэгт Монголын уул уурхайн салбарын нүүр царай болсон “Оюу толгой”-н алс хэтийн болон стратегийн төлөвлөгөөг харуулна. Байгалийн баялаг ихтэй гээд чинээлэг, аз жаргалтай улс болдоггүйг олон орны түүх харуулдаг. Гэсэн ч байгалийн баялаг ихтэй, залуу эдийн засаг бүхий Монгол Улсад бусдын алдааг давтахгүйгээр эрдэс баялгаа зөв удирдаж, эдийн засгаа хөгжүүлэх бүх өгөгдөл байгаа билээ.



Хуудас 59. Хэрхэн хүчирхэг уул уурхай бүхий өндөр хөгжилтэй улс болох вэ?



Хуудас 42. Эдийн засгийн бүхий л салбарт нэмүү өртөг бий болгох нь



Хуудас 60. Эрдсийг баялаг болгох нь



Монгол: Уул уурхайн цахиур хагалах тоглогч

Нүүдэлчдийн өнө эртний бахдам түүхтэй Монгол Улс байгалийн нөөцдөө түшиглэн эдийн засгийн шилжилт хийж, чамлахааргүй хөрөнгө татаж чадсан юм. Энэ өөрчлөлт нь хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлж, тогтвортой өсөлтийг хангахад хувь нэмрээ оруулах бүрэн боломжтой. Уул уурхай нь эдийн засгийн агуулгаараа аж үйлдвэрийн бусад салбараас ялгагдах онцлог шинж чанартай. Монгол Улс эдийн засгаа өсгөх, тогтвортой хөгжлийг хангахын тулд дээрх ялгаатай шинж чанарыг онцгой анхаарах нь чухал билээ. Ингэснээр уул уурхайгаас хүртэх үр өгөөжийг хамгийн дээд түвшинд хүргэж, учирч болох бүхий л эрсдэлийг бүрэн удирдах боломжтой болдог. Монгол Улсыг энэхүү амаргүй даваа хүлээж байгаа ч гайхалтай боломж нээлттэй хэвээр байна.



Монгол

Эх нутаг


Монголчууд байгаль, газар дэлхийтэйгээ хүйн холбоотой. Бахдам, баялаг нүүдэлчний соёлтой Монгол орон хатуу ширүүн уур амьсгалтай боловч сэтгэл татам өргөн уудам нутагтай учир байгальтайгаа нандин шүтэлцээтэй улс. Эртнээс улбаатай түүхийнхээ дийлэнхэд Монголын эдийн засаг нүүдэлчин хэв маягийн мал аж ахуйг түшиж ирсэн юм. Далайд гарцгүй Монгол хорьдугаар зууны ихэнхэд Зөвлөлт Холбоот Улсаар л дамжуулан гадаад зах зээлтэй холбогдож иржээ. Зөвлөлт Холбоот Улс задармагц Монгол нийгэм, эдийн засгийн огцом, хэцүү өөрчлөлт хийж, ардчилалд суурилсан зах зээлийн тогтолцоонд шилжсэн билээ.

Өөрчлөлтэй нүүр тулав

Монгол Улс уламжлалт мал аж ахуйн өв соёлоо хадгалахыг хичээхийн зэрэгцээ ашигт малтмалын нөөцдөө түшиглэн эдийн засгаа хөгжүүлэх стратегийг богино хугацаанд хэрэгжүүлж чадав. Энэ шийдвэр нь эдийн засгийн хөгжлийг дараагийн шатанд гаргах хөшүүрэг болсон билээ. Учир нь дэлхийд санхүүгийн хямрал нүүрлэж, эрсдэлээс зайлсхийсэн уул уурхайн томоохон компаниуд улс дамнах хөрөнгө оруулахаа бараг зогсоогоод байсан үед Монгол Улс “Оюу толгой” төслийг хөдөлгөж чадсан юм. Ингэснээр дэлхийн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын салхины чигийг сөрж чадав.

Урьд өмнө үзэгдээгүй гадаадын энэхүү том хөрөнгө оруулалт нь Монголын уул уурхайн хайгуул болоод бүтээн байгуулалтын салбарыг хөгжүүлээд зогсохгүй тус улсыг сүүлийн арав гаруй жилд дэлхийн хамгийн хурдацтай өсөж буй эдийн засагтай улсын нэг болгожээ. Ийн хэлэхийн учир нь энэ хугацаанд зэсийн баяжмалын үйлдвэрлэл дөрөв дахин, алтны гарц гурав дахин нэмэгдсэн байна. Үүгээр зогсохгүй бусад ашигт малтмалын олборлолтод хөрөнгө оруулах дуудлага болж, мөн хугацаанд нүүрсний олборлолт гурав дахин нэмэгджээ. Үүний үр дүнд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн огцом өсөж, энэ хэрээр нийгэм, эдийн засгийн олон үзүүлэлтэд эерэг өөрчлөлт гарсан байна. 2002 онд хүн амын дунд эзлэх ядуурлын түвшин 36 хувь байсан бол 2014 онд 22 хувь болж буурчээ.

Зураг 1. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт орж эхэлснээс хойших нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт




Эх сурвалж: Дэлхийн банк

Татаж авах

Эдийн засгийн уналт ба сэргэлт

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарын өсөлтийг даган тэлэхийн хэрээр байгалийн нөөцөөс улам бүр хараат болж эхэлсэн нь эдийн засагтаа эргээд сэргөөр нөлөөлөх боллоо. Ашигт малтмалын салбарын хурдацтай өсөлтийн ачаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, эрдэс баялгийн экспорт өсөж, Засгийн газар уул уурхайн салбараасаа голлох орлогоо олдог болов. Гэвч үүнийг дагаад улсын эдийн засаг нь дэлхийн уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд эмзэг болж, инфляцийн дарамтад бодитой орж, валютын ханшийн өсөлтөд өртөв. Улмаар энэхүү нөхцөл байдал уул уурхайгаас бусад салбарын өртгийг өсгөж, өрсөлдөх чадварыг нь бууруулсан юм.

Зураг 2. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт Монгол Улсын макро эдийн засгийн удирдлагыг сорьсон юм



Татаж авах

Эх сурвалж: Монгол банк; Үндэсний статистикийн хороо; Дэлхийн банк; ОУВС

Бодит байдал дээр 2009-2011 онд гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 12 хувиар чангарснаас аялал жуулчлал, ноолуур зэрэг салбарын экспорт хүнд байдалд оржээ. Түүнчлэн уул уурхайн салбарын өндөр цалингаас улбаалан ур чадвартай ажилчид энд төвлөрч дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт чадварлаг хүний нөөц дутагдах бэрхшээл үүссэн байна.

Монголын эдийн засаг тогтворгүй хэвээр байна. 2011 оноос хойш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарахын сацуу дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ унасны улмаас эдийн засаг нь асар хүнд байдалд орсон юм. Эрдэс баялагт суурилсан эдийн засагтай улс орнуудад тохиолддог орлого талын ийм савлагаа нь улс орныг энэ нөхцөлд түргэн дасан зохицож хариу үйлдэл үзүүлэх, “бүсээ чангалах”-ыг шаарддаг. Гэвч гаднын цочир нөлөөн дээр зардлын удирдлагаа зөв хийж чадаагүйгээс төсвийн үрэлгэн зарлага үлэмж нэмэгдсэнээр эдийн засаг нуран унах шахсан юм. Тухайлбал, төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ий 17 хувьтай тэнцэж, улсын өр ДНБ-ий 90 хувьтай тэнцэхүйц хэмжээнд хүрч, төгрөгийн ханш огцом суларч, инфляци эрс өссөн байна. Төрөөс сангийн бодлогоо тэлэх гэж оролдсон ч 2016 онд эдийн засгийн өсөлт нэг хувь хүртэл буурчээ. Ингэснээр ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн халамжийн олон хөтөлбөр, санхүүжилт нь эдийн засгаа доош чирч эхэлсэн юм.

“Монгол Улсын уул уурхайн салбар 2008 оноос хойш огцом өссөн боловч байгалийн нөөцөө хэрхэн улс орны хөгжлийн хөдөлгүүр болгох арга замаа хараахан сонгоогүй байна”.

Ингээд эдийн засгийг сулруулаад зогсохгүй улсын төсвийг ч хүнд байдалд оруулсан. Улмаар Засгийн газар ОУВС-гаас санал болгосон 5.5 тэрбум ам.долларын өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг 2017 онд хэрэгжүүлэхээс өөр аргагүй болсон билээ. Үүний дүнд эдийн засгийн нөхцөл дээрдсэний сацуу уул уурхайн салбар, ялангуяа дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ өсөж, барилгын салбар ч сэргэж эхэллээ.

Уул уурхайн салбар

Үнэ, мөчлөг, эрсдэл

Уул уурхай нь бусад аж үйлдвэрийн салбараас ихээхэн ялгаатай. Уул уурхайд тулгуурласан эдийн засгийг амжилттай хөгжүүлэхийн тулд энэ ялгааг онцгой анхаарах ёстой. Тухайлбал, уул уурхайн төсөл эхэлмэгц их хэмжээний хөрөнгө оруулалт шаардах нь хөдөлбөргүй үнэн. Ингэснээр нэг талаас тухайн компанийн үнэ цэнийг өсгөөд зогсохгүй улс орны эдийн засгийн чадавхийг ч нэмэгдүүлдэг. Үүгээр дан ганц санхүүгийн шинэ эх үүсвэр ч бус шинэ мэдлэг, мэдээлэл, технологи, инноваци, бүтээмжийг тухайн улсад давхар оруулж ирдэг. Нөгөө талаас хөрөнгө оруулагчдын хүсэж буй өгөөж нь урьдчилан оруулсан их хэмжээний хөрөнгө болон хөрөнгө оруулахад алдагдсан бусад боломжийг ч нөхөхүйц хэмжээнд байх ёстой. Алс ирээдүйд гарах бизнесийн үр ашгийн төлөө бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, борлуулалтын гэх мэт бизнесийн бүтэн мөчлөгийг туулах зуур хөрөнгө оруулагч эдийн засгийн тодорхойгүй байдал, эргэлзээтэй нөхцөлтэй нүүр тулах нь ч бий.

Ийм нөхцөл байдал нь уул уурхайн салбарт хууль, эрх зүйн тодорхой зохицуулалт ямар чухал вэ гэдгийг нотолж байна. Нэгэнт хөрөнгө оруулалт хийсэн томоохон уурхайнуудад асар их мөнгөн урсгал орж ирдэг учир төрийн болоод хувийн хэвшлийнхний анхаарлыг эрхгүй татдаг. Тэдний дунд өнөө маргаашийн ашиг олох сонирхолтой, “маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушгийг” эрхэмлэгч, явцуу бодолтон цөөнгүй бий. Тиймээс хөрөнгө оруулалтын таатай нөхцөл, тусгай зөвшөөрлийн баталгаа, зохицуулах байгууллагын ил тод байдал, төрийн тогтвортой бодлого, гэрээгээ хариуцлагатай биелүүлэх зэрэг үзүүлэлт эх орондоо хөрөнгө оруулалт татахыг эрмэлзэж буй улс орнуудын өрсөлдөөнд ялах гол хүчин зүйл болдог.

“Монголчууд газар доорх байгалийн нөөцийнхөө эзэд мөн. Гэхдээ ашигт малтмалыг олборлон боловсруулж, зах зээлд арилжиж байж л үнэ цэнэ бүхий бодит баялаг бий болдог. Хөрөнгө оруулагчид болон уул уурхайн компаниуд нь Засгийн газартай харилцан ашигтай хамтран ажиллах зарчмаар санхүүжилт босгох, мэргэжлийн ур чадварыг нутагшуулах онцгой эрх авдаг. Үүгээр тэд хөрсөн доор унтаж буй баялгийг газар дээр үнэ хүргэх чухал үүрэг хүлээдэг”.

Бусад салбараас илүүтэйгээр уул уурхайн салбарт нөлөөлдөг бас нэгэн хүчин зүйл бол үнийн эрсдэл юм. Учир нь, уул уурхайн бараа бүтээгдэхүүний үнэ байнга хэлбэлзэж байдаг. Салбарын хэмжээнд урт хугацааны зах зээлийн хүлээлтийг богино хугацааны нөхцөл байдлаар үнэлэх, ирээдүйн үнийг өнөөгийн үнээр тооцох хандлага бий. Үүний үр дагавраар уул уурхайн салбарын бодит ашиг бусад салбаруудтай харьцуулахад мэдэгдэхүйц бага байдаг.

Мөн уул уурхайн салбарын бизнесийн мөчлөг үнийн эрсдэлд нөлөөлдөг. Яагаад гэвэл, энэ салбарт эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүссэнээс ашигт малтмалын үнэ дээд болон доод цэгийн хооронд огцом хэлбэлзэх нь хэвийн үзэгдэл байдаг. Үйл ажиллагааны зардал өндөртэй уурхай дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн өндөр үнэд найдан төлөвлөлтөө хийдэг учир үнэ унах тохиолдолд үйл ажиллагаа нь зогсож дампуурах эрсдэлтэй тулдаг. Үнийн уналтыг давж гарахын тулд уурхайн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны нэгж зардлыг аль болох бууруулах нь чухал. Ингэснээр Засгийн газар, орон нутаг, хөрөнгө оруулагчдад ногдох үр өгөөжийг тогтвортой байлгах гол нөхцөл бүрддэг.

Үүнээс гадна уул уурхайн салбарт дараах техникийн эрсдэл бий. Үүнд геологийн (ордын нөөцийн хэмжээ, агуулга, олборлогчийн үр ашигтай ажиллах чадвар); тусгай зөвшөөрлийн (бүтээн байгуулалтын ажил болон уурхайг удирдах үйл ажиллагааны цаг хугацааны нөлөөлөл); металлургийн (олборлох металлын хэмжээ, аргачлал болон зардал, хольц, дайвар бүтээгдэхүүн); хөрөнгийн (бүтээн байгуулалтын зардал болон цаг хугацаа, гэнэтийн зардлын хэтрэлт, уурхайн хаалтын төлөвлөгөө болон зардал); үйл ажиллагааны (үйлдвэрлэлийн хэмжээ, үйл ажиллагааны зардал болон тасалдал); маркетингийн (эрэлтийн хэлбэлзэл, өрсөлдөөн, тээврийн зардал, тариф, татаас) гэх мэт эрсдэлүүд багтана.

Зураг 3. “Оюу толгой”-н нийт хөрөнгө оруулалтыг Монголын эдийн засагтай харьцуулбал



ЗЭСИЙН ЗАХ ЗЭЭЛ

Сэргээгдэх эрчим хүчний хувьсгалын түлхүүр

Зэсийн хэрэглээ эдийн засгийн өсөлттэй нягт холбоотой. Дэлхийн зэсийн нийлүүлэлт 2020 оноос эхлэн хомсдох төлөвтэй байгаа. Монгол Улс зөв байршиж чадвал энэ нөхцөлөөс ашиг олох бүрэн боломжтой.

Дэлхийн зэсийн хэрэглээ (2015)



Зэс ногоон хувьсгалыг тэтгэдэг

Цахилгаан дамжуулалт (кабель), хадгалалт (зай) дээр тулгуурладаг ногоон эрчим хүч рүү дэлхий даяар шилжиж буй нь зэсийн эрэлт хэрэгцээг улам нэмэгдүүлж байна.



Цахилгаан дамжуулах чадвар сайн



Дулаан дамжуулалт сайн



Дахин ашиглах боломжтой

ЗЭСИЙН ХЭРЭГЛЭЭ

Зэс цахилгаан хамгийн сайн дамжуулдаг учраас сэргээгдэх эрчим хүчний хувьсгалд хамгийн чухал үүрэгтэй метал юм. Зэсийг дараах байдлаар ашигладаг (жингээр харуулав).




4,000кг

1 МВт-ын нарны хавтан



3,600кг

1 МВт-ын салхин сэнс



83кг

Цахилгаан машин



20кг

Цэнэглэх станц

Сэргээгдэх эрчим хүч нь МВт тутамд үл сэргээгдэх эрчим хүчнээс дөрөв дахин их зэс ашигладаг.

75%

Дэлхий дээр үйлдвэрлэсэн нийт зэсийн 75 хувийг цахилгааны утас, үйлдвэрийн суурь машинд ашигладаг

2002


2007

2012

ЭРЭЛТИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ


Цахилгаан машинд шаардлагатай зэс

(сая тонноор, төсөөлөл)



Нар, салхины эрчим хүч

Дэлхийн үйлдвэрлэх нийт хүчин чадал (ГВт)



50%

Дэлхийн зэсийн нийт эрэлтийн тэн хагас Хятад улсад ногддог

- Боломжит төслүүд
- Өндөр магадлалтай төслүүд
- Үйлдвэрлэлийн боломж
- Эрэлт




“Оюу толгой”-той тэнцэхүйц найман шинэ уурхайг 10 жилийн дотор барьж гэмээнэ дэлхийн таван сая тонн зэсийн нийлүүлэлтийн хомсдолыг нөхөх боломжтой.

НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ


Одоо ашиглаж буй уурхайнуудын нөөц шавхагдаж, зэсийн дундаж агуулга буурч байгаагаас гадна шинэ уурхайг богино хугацаанд ашиглалтад оруулах боломж хомс байгаа учраас нийлүүлэлт багасаж байна.

Зэсийн агуулгын бууралт

Агуулгын дундаж хувь, %



Уурхайг илрүүлснээс хойш үйлдвэрлэлд шилжүүлэх дундаж хугацаа жил ирэх тусам уртассаар байна. (жилээр)



НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХОМСДОЛ

2017

2022

2027



The background image shows a large-scale mining operation. A massive circular structure, possibly a conveyor or part of a processing plant, dominates the upper left. Heavy machinery, including what looks like a large drill or excavator arm, is visible in the foreground and middle ground. The scene is dark and industrial, with a blue tint. The title text is overlaid in the center.

Оюу толгой: Дэлхийн энтэй уурхай

“Оюу толгой” ХХК бол Монголын компани. “Оюу толгой”-г Монгол Улсын Засгийн газар, “Рио тинто” болон “Туркойз хилл ресурс”-ын хувьцаа эзэмшигчид хамтран эзэмшдэг. “Оюу толгой” шиг нүсэр том, цогц төсөл оролцогч талуудын мэдлэг, техникийн ур чадвар, салбарын туршлага, санхүүгийн чадамжийн үрээр амжилттай хэрэгждэг. Дэлхийн хэмжээний ийм том санхүүгийн хөрөнгө оруулалт нь оролцогч бүх талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлсон багц гэрээнүүдээр баталгааждаг. Үе шаттай хэрэгжиж буй “Оюу толгой”-н бүтээн байгуулалт төгс гүйцэтгэлээрээ дэлхий дахинд хэдийнээ танигджээ. Алсыг харсан бодлого, зөв удирдлагын хүчээр “Оюу толгой” Монголын хөгжлийн түүчээ болж чадна.

Ордын нээлт, бүтээн байгуулалт

Дэлхийд дуурсах том ордыг нээсэн түүх

Оюу толгойд зэс байгааг олж мэдсэн нь хүрэл зэвсгийн үеэс улбаатай. Харин орчин цагийн геологийн судалгаагаар 1980-аад оны үед зэсийн эрдэсжилт байгааг тэмдэглэж үлдээжээ. 1997 онд Ашигт малтмалын тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар анх удаа хувийн хөрөнгө оруулалтаар хайгуул, олборлолт хийх боломж бүрдсэн.

Оюу толгойн орчимд хайгуулын ажил хийх анхны лицензийг 1997 онд Австралийн “Би Эйч Пи” компани авсан ч уурхай болох хэмжээний ашигт малтмалын нөөц олж чадахгүй байлаа. Канадын “Айвенхоу майнз” компани 1999 онд “Би Эйч Пи” компанитай түншилсэн ч “Би Эйч Пи” Монголоос гарснаар “Айвенхоу майнз” компани Оюу толгойн хайгуулын тусгай зөвшөөрлийн үндсэн эзэмшигч болж үлджээ. Хайгуулыг удтал үргэлжлүүлж, эцэстээ санхүүжилт дуусах үед Монголын ахлах геологич 150 дугаар цооногийг өрөмдөж үзэх санал дэвшүүлжээ. Чухам эндээс өнөөгийн Оюу толгой олдож, эдийн засгийн үр ашиг бүхий уурхай нээж болохуйц зэс, алт, мөнгө, молибдений хангалттай агуулгатай нөөцийг илрүүлсэн юм. Монгол геологичид ур чадвартай, зоримог, шийдэмгий байгаагүй бол энэ баян нөөц хөрсөн дороо үүрд хаягдах байлаа.

Хайгуулын хөтөлбөрөө өргөжүүлж, өрмийн машиныхаа тоог нэмснээр асар их хэмжээний зэс-алтны нөөцтэй, дэлхийд томоохонд тооцогдох ордыг илрүүлжээ. Гэхдээ олборлолтын өөр төрөл буюу гүний уурхайн аргаар олборлох шаардлагатайг тогтоосон юм. Газар доорх нөөцийг олборлож баялаг болгоход асар нарийн техник төхөөрөмж, эрчим хүч, төмөр зам гэх мэт дэд бүтэц шаардлагатай байлаа. Иймээс дэлхийн зиндааны том олборлогчдын мэдлэг, туршлага, техник, санхүүгийн чадавхийг ашиглах шаардлага зүй ёсоор урган гарсан билээ. Ингээд “Айвенхоу майнз” болон “Рио тинто” 2006 оны аравдугаар сард стратегийн түншүүд болсон юм.

Бүтээн байгуулах зөвшилцөл


Хэд хэдэн Засгийн газар дамнан зөвшилцсөөр 2009 оны аравдугаар сард Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурав. Гарын үсэг зурмагц бүтээн байгуулалтын нэгдүгээр үе шатны ажил эхэлж долоон мянга гаруй ажилтны хүчээр ил уурхай, баяжуулах үйлдвэр, түүнийг дагалдах дэд бүтцийг барьж байгуулах ажил эхэлсэн юм. Оюу толгойн баяжуулах үйлдвэр бол Монголын аж үйлдвэрийн салбарын хамгийн том, орчин үеийн байгууламж бөгөөд анхны бүтээгдэхүүнээ төлөвлөсөн хугацаанаасаа өмнө буюу 2013 оны 1-р сард гаргажээ. Ил уурхайн олборлолттой зэрэгцээд 2015 онд Монгол Улсын Засгийн газартай гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөг тохирсноор олон улсын банк, санхүүгийн консорциумаас 4.4 тэрбум ам.долларын санхүүжилт богино хугацаанд босгов.

“Оюу толгой” бол Монгол Улсын түүхэнд нэг төсөлд оруулсан хамгийн том хөрөнгө оруулалт болоод зогсохгүй дотоодын хамгийн том уурхай болжээ. Оюу толгойн уурхай үйл ажиллагааныхаа туршид ойр ойрхон орших бүлэг ордоосоо хүдэр олборлоно. Баяжуулах үйлдвэрийн боловсруулж буй хүдэр 2020 оноос эхлэн шат дараатайгаар ил уурхайгаас гүний уурхайн хүдэрт шилжинэ. Ил уурхайтай харьцуулахад гүний уурхайн хүдэр дэх алт, зэсийн агуулга өндөр учир үйл ажиллагааны нэгж зардал багасч, үр ашиг харьцангуй нэмэгдэнэ. Гүний уурхайд Оюу толгойн нийт баялгийн 80 орчим хувь нь бий.

Баяжуулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахад хоногт 100 мянган тонн хүдэр боловсруулж алт, зэс, мөнгө ялгах хүчин чадалтай. Оюу толгой одоо 40 жилийн түүхтэй “Эрдэнэт” үйлдвэрээс илүү хүдэр олборлож, илүү их зэсийн баяжмалыг боловсруулан гаргаж байна. 2017 онд “Оюу толгой” нийтдээ 157,4 мянган тонн зэс, 114 мянган унци алт 974 мянган унци мөнгө агуулсан баяжмал үйлдвэрлэжээ. Боловсруулсан зэсийн баяжмалаа ачааны тэргээр тээвэрлэн Хятадын зэс хайлуулах үйлдвэр, зэсийн худалдаа эрхлэгчдэд нийлүүлж байна. Уурхайн үйл ажиллагаа гүний уурхайн олборлолт руу шилжих тусам хүдрийн агуулга нэмэгдэж, тэр хэрээр жилийн үйлдвэрлэлийн хэмжээ эрс өснө.

Оюу толгой шиг чанартай том орд Монголын хэдэн үеийг тэжээх баялаг юм. Одоогийн тогтоосон ил болон гүний уурхайн хүдрийн нөөцөөр Оюу толгой ирэх 40 жилийн турш ажиллана. Ингээд зогсохгүй ойролцоох гүний уурхайн бусад бүлэг ордыг олборлосноор зуугаас ч илүү жил ажиллах боломжтой.

Зураг 4. Гүний уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр Оюу толгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл гурав дахин нэмэгдэнэ.



Татаж авах

Эх сурвалж: Туркойз Хилл Ресурсес

“Оюу толгойн ажиллах хугацаа болон далайц нь Монгол Улсын хөгжлийн гол хөдөлгөгч хүч болоод зогсохгүй олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг байнга татдаг дэлхийн уул уурхайн салбарын сонгодог хөрөнгө оруулалтын жишээ болсоор байна”.

Эзэмшил, удирдлага

Харилцан ашигтай түншлэл

“Оюу толгой” ХХК бол Монгол Улсыг дэлхийн уул уурхайн тэргүүлэгч улс болгох их үйлсэд хөтөлж буй монгол компани юм. “Оюу толгой” компанийн 34 хувийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж “Эрдэнэс Оюу толгой” ХХК, 66 хувийг Канадад төвтэй “Туркойз хилл ресурс” компани эзэмшдэг. Харин “Туркойз хилл ресурс” компанийн 51 хувь нь “Рио тинто” группийн эзэмшилд байдаг. Эдгээр хөрөнгө оруулагчид хамтраад эрдэс баялгийн эзэд болсон Монголын ард түмнийг төлөөлж, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчмаар төслийг амжилттай удирдан, уул уурхайн салбарын тэргүүний мэдлэг, туршлагыг нэвтрүүлж, олон улсын санхүүгийн зах зээлд гарах боломжийг бүрдүүлж байна.

“Оюу толгой” компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болсон Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) хэрэгжүүлдэг. ТУЗ нь компанийн стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж өгнө. Мөн ТУЗ-ийн дэргэд хэд хэдэн хороод байгуулагдан ажилладаг бөгөөд Аудит, Санхүүгийн хороог Засгийн газрын томилсон ТУЗ-ийн гишүүн ахалдаг байна. Уурхайн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд тогтвортой явуулах үүднээс хувьцаа эзэмшигчид санал нэгтгэйгээр “Рио тинто” компанид удирдлагын эрхийг хариуцуулсан юм. “Оюу толгой” шиг өргөн цар хүрээтэй ордын үйл ажиллагааны удирдлагыг салбартаа дэлхийд хоёрдугаарт жагсдаг, мэргэжлийн компанид даалгасан нь хамгийн оносон зөв шийдвэр билээ.

“Оюу толгой” бол дотоодын мэдлэг, ур чадвар болон олон улсын хөрөнгө оруулагчдын техникийн чадвар, мэргэжлийн чадавхи, санхүүгийн нөөцөөр баталгаажсан дэлхийд тэргүүлэх Монголын уул уурхайн компани билээ. Монгол Улсын Засгийн газар ТУЗ-ийн гишүүдээрээ дамжуулан компанийн стратегийг тодорхойлоход идэвхитэй оролцдог”.

2010 оноос эхлэн “Оюу толгой”-н удирдлагыг дэлхийн хамгийн том зэсийн хоёр уурхайн хувьцаа эзэмшигч, гүний уурхайн арвин туршлагатай “Рио тинто” компани хариуцаж байгаа бөгөөд “Туркойз хилл ресурс” компанийн хамт жил бүр “Оюу толгой” компанийн орлогын гурван хувийг менежментийн төлбөр болгон авна. Мөн “Рио тинто”, “Туркойз хилл ресурс” нь бүтээн байгуулалтын үндсэн санхүүжүүлэгч юм. Хувьцаа эзэмшигчид гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил дуусах хүртэл нийт долоон тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлнэ.

Төрийн оролцоо

Монгол Улсын газрын хэвлийд оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч тул төр өмчлөгчийн хувьд ашигт малтмал хайх, ашиглах эрхийг бусдад олгох эрхтэй. Түүнчлэн санхүүгийн болон эрх зүйн бүхий л бодлогыг тодорхойлдог. Ашигт малтмалын тухай хуульд зааснаар стратегийн ач холбогдол бүхий ордод хувь эзэмших эрхтэй байдаг. Төр, улмаар Монголын ард түмэн дээрх эрхүүдээрээ дамжуулан ашигт малтмалын олборлолтоос ашиг хүртэх боломжтой.

Төр дээр дурдсан гурван чиг үүргийнхээ хүрээнд шаардлагатай хөрөнгө, техникийн чадамжтай гадаадын хөрөнгө оруулагчийн сонирхлыг татахуйц таатай орчныг бүрдүүлэх, эдгээр хөрөнгө оруулагчидтай ашиг болон эрсдэлээ шударгаар хуваалцах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал. Хөрөнгө оруулагч болон төр эрсдэл болон ашгийг тэгш хуваарилах зорилгоор татварын болон татварын бус арга хэрэгслийг хослуулан ашиглах боломжтой. Хөрөнгө оруулагчид татварын хувь хэмжээг бус харин олж болох ашгийн доод хэмжээг баталгаажуулахыг зорьдог тул төрөөс татварын хувь хэмжээг тогтоохдоо ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татвар болон хөрөнгө оруулсан хувь хэмжээний нөлөөг бүхэлд нь харгалзан үзэх шаардлагатай.

Эрдэс баялгийн эзэн

Төр нь эрдэс баялгийн эзний хувиар олборлосон эрдэс баялаг бүрээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр авдаг. Уурхайн олборлолт эхэлсэн даруйд хөрөнгө оруулагч тал ашиг олж эхэлсэн эсэхээс үл хамааран төр энэ төлбөрийг шууд авч эхэлдэг юм. Монголын хувьд уг төлбөрийн хэмжээ экспортод гарч буй баялгийн таван хувь байдаг бөгөөд бусад оронтой харьцуулахад өндөрт тооцогддог.

Эдийн засгийн болон эрхзүйн бодлого тодорхойлогч

Монгол Улсын нутаг дэвсгэрт уул уурхай болон аж ахуйн бусад үйл ажиллагааг явуулахад мөрдөгдөх хууль тогтоомж, мөнгөний бодлогыг төрөөс тогтооно. “Оюу толгой”-н уурхай үйл ажиллагаагаа эхлээд удаагүй ч ихээхэн хэмжээний татварыг төсөвт төлөөд байна. Монголд үйл ажиллагаа явуулж буй зарим уурхайтай харьцуулахад “Оюу толгой” холбогдох бүхий л татварыг анхнаасаа элдэв хөнгөлөлт, чөлөөлөлтгүйгээр төлж ирсэн. Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, суутган татвар, гаалийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар зэргийг энд дурдаж болох бөгөөд өдгөө “Оюу толгой” ХХК нь Монголын тэргүүлэх татвар төлөгч хэдийнэ болоод байна.

Хөрөнгө оруулагч

Аливаа төр уул уурхайн төсөлд хувь эзэмшсэнээр эдийн засгийн ашиг сонирхлоо төслийн үр өгөөжтэй уялдуулах боломжтой байдаг. Төсөл ашигтай ажиллах тусам хөрөнгө оруулагчийн хувьд төрийн хүртэх ногдол ашиг нэмэгддэг. Хэдий тийм ч хувьцаа эзэмшиж буй төр зах зээлийн эрсдэлийг хамт үүрэлцэх үүргээ заримдаа хөсөрдүүлэхийг оролддог. Санхүүжилт хийх боломжгүй тохиолдолд төрөөс оруулбал зохих хөрөнгийг бусад хөрөнгө оруулагчид нь оруулж, төрийн ирээдүйд хүртэх ногдол ашгаас оруулсан хөрөнгө, түүнд ногдох хүүгийн төлбөрийг төлж барагдуулах боломжтой байдаг.

Үндсэн гэрээнүүд

Эрх зүйн зохицуулалт

Ашигт малтмал ард түмний өмчлөлд байдаг. Уул уурхайн компаниуд ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох тусгай зөвшөөрөл авах шаардлагатай. Компаниуд ашигт малтмалын нөөц ашигласныхаа хариуг төлбөр, татвар болон бусад хэлбэрээр төлдөг. Уул уурхайн төслийн үр өгөөжийг хэрхэн хуваах талаар Засгийн газрууд уул уурхайн компаниудтай хөрөнгө оруулалтын болон бусад гэрээг байгуулдаг.

“Уул уурхайн гэрээний зорилго нь талуудын харилцан ашигтай хөрөнгө оруулалтын нөхцөлийг тодорхойлж, нэмүү өртөг бий болгоход оршдог. Оюу толгойн ордыг ашиглах гэрээнүүд олон нийтэд нээлттэй бөгөөд тэдгээрийг холбогдох талууд нарийвчлан хянасан байдаг”.

Төслийн үр өгөөжийг хуваарилах зарчмыг тодорхойлохоос гадна эдгээр гэрээнүүдэд төслийн үргэлжлэх хугацаанд оролцогч талуудын эрх, үүргийг зааж өгсөн байдаг. Засгийн газрын зүгээс, тухайлбал, байгаль орчны стандарт, ажлын байр, дэд бүтэц, нийгмийн хөрөнгө оруулалт зэргийг баталгаажуулдаг. Харин хөрөнгө оруулагчид уурхайн бүтээн байгуулалт, өргөтгөлийг санхүүжүүлэхэд шаардлагатай олон тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхийн тулд тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой бизнес, хууль эрх зүйн орчныг баталгаажуулахыг хүсдэг. Дээрх нөхцөлүүдийг харилцан тохирсон үндсэн гэрээгүйгээр “Оюу толгой” мэт томоохон төслүүд дэлхийн аль ч улсад хэрэгжих боломжгүй. Учир нь, хөрөнгө оруулалтын нөхцөлд ирээдүйд аливаа өөрчлөлт ороход хөрөнгө оруулагчид ихээхэн эрсдэлд ордог.

Гэрээний хэлэлцээр хийх эрх болон байгуулсан гэрээний нөхцлүүд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжинэ. Цаашилбал, төрийн эрх бүхий байгууллагуудын хэлэлцэн тохиролцсон гэрээний нөхцөлүүдийг Улсын Их Хурлаас баталдаг. Түүнчлэн, хувь нийлүүлэгчдийн гэрээгээр компанийн хувь нийлүүлэгчид хоорондын харилцааг зохицуулдаг. Оюу толгой төслийн тухайд, хувь нийлүүлэгчдийн гэрээгээр “Оюу толгой” ХХК болон тус компанийн хувь нийлүүлэгчид компанийн удирдлага, засаглал, санхүүжилт, үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар тохиролцсон байдаг.

“Оюу толгой”-н бүтээн байгуулалтыг шат дараатай төлөвлөсөн бөгөөд анх ил уурхайг ажиллуулж эхэлсэн бөгөөд цаашид илүү үр ашигтай гүний уурхайг барьж эхлээд байна. “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-г 2015 онд баталснаар ил уурхайн барилгын ажлын үед үүссэн асуудлууд болон гүний уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай хэд хэдэн чухал асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн билээ.

ҮНДСЭН ГЭРЭЭНҮҮД

Монгол Улсад урьд өмнө хийж байгаагүй их хөрөнгө оруулалтын үндсийг тавив




Хөрөнгө оруулалтын гэрээ (IA)

Хөрөнгө оруулалтын гэрээгээр Оюу толгой ХХК-ийн үйл ажиллагаа явуулах орчин болон татварын асуудлыг тохирсон. Гэрээг Засгийн газрын түвшинд хэлэлцэн тохирч, эрх бүхий төрийн бүх байгууллагууд хянан баталгаажуулсан юм. Хөрөнгө оруулалтын тогтвортой нөхцөлийг баталгаажуулсны хариуд нийгэм-эдийн засгийн үр өгөөж, байгаль орчны менежментийн талаар олон үүрэг, хариуцлагыг хөрөнгө оруулагчдад гэрээгээр хүлээлгэсэн билээ. Үндсэн нөхцлүүдээс дурдвал:

Гэрээнд гарын үсэг зурсан огноо 2009 оны аравдугаар сарын 6

Гэрээний хугацаа	30 жил, 20 жилээр сунгах нөхцөлтэй
Засгийн газрын эзэмших хувь	34 хувь, 30 жилийн дараа 50 хувь хүртэл өсгөх боломжтой
Татварын тогтворжуулалт	Өмнө нь байгаагүй том хөрөнгө оруулалтыг урт хугацаанд хадгалах үүднээс гэрээ байгуулах өдрийн байдлаарх татварын хувь хэмжээгээр зарим татварыг тогтворжуулсан
Татвар	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, гаалийн татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татварыг гэрээг байгуулах өдрийн байдлаарх хувь хэмжээгээр тогтворжуулсан.
Дэд бүтэц	Нисэх онгоцны буудал, БНХАУ-ын хил хүртэл зам барих; эрчим хүчний хэрэгцээгээ дотоодын эх үүсвэрээс хангах (дотоодод эрчим хүчний эх үүсвэр буй болсон тохиолдолд); өөрийн илрүүлсэн усны нөөцийг ашиглах эрх
Ажил олголт	Нийт ажиллах хүчний 90-ээс доошгүй хувьд Монгол Улсын иргэдийг авч ажиллуулна. Бүтээн байгуулалт болон үйлдвэрлэлийн аль ч шатанд ажиллах гэрээт компаниудад дээрх шаардлагыг тавина. Өргөн цар хүрээтэй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, Монгол Улсын иргэдийг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна
Бүс нутгийн хөгжил	Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлд бодит хувь нэмэр оруулна. Орон нутгийн захиргаатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана.
Байгаль орчин	Уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг өөрийн зардлаар арилгана. Байгаль орчинд учруулсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн төлнө. Жил бүр аудит хийлгэнэ.



Нэмэлт өөрчлөлт оруулж, дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ (ARSHA)

Компанийн засаглал, менежмент, санхүүжилт, дотоодын худалдан авалтыг дэмжиж ажиллах асуудлуудыг тодорхойлсон юм. Тухайлбал, хөрөнгө оруулагчид Засгийн газрын өмнөөс Засгийн газрын эзэмших хувьд ногдох хөрөнгийг гаргаж ирээдүйд төслөөс олох ашгаас эргүүлэн авах нөхцөлийг тохирсон болно.

Гарын үсэг зурсан	2011 оны зургадугаар сарын 8
Засаглал	"Туркойз хилл ресурс" компани нь ТУЗ-ийн даргыг оролцуулан ТУЗ-ийн зургаан гишүүнийг; "Эрдэнэс Оюу толгой" ХХК нь ТУЗ-ийн гурван гишүүнийг томилно. ТУЗ Оюу толгой ХХК-ийн жилийн төсвийг батална..
Гүйцэтгэх удирдлага	"Рио тинто" групп нь Оюу толгой ХХК-д стратегийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж, менежментийн үйлчилгээний төлбөр авна.
Засгийн газрын эзэмшил	Засгийн газрын эзэмших 34 хувийг урьдчилгаа төлбөргүйгээр төрийн өмчит "Эрдэнэс Оюу толгой" ХХК-д шилжүүлнэ.
Засгийн газрын хувьцааны зардлыг гаргах нь	Хөрөнгө оруулагчид гүний уурхайн олборлолт эхлэх хүртэл шаардагдах хөрөнгийг 100 хувь гаргах бөгөөд Засгийн газрын эзэмшлийн хувьд ногдох санхүүжилтэд LIBOR дээр нэмэх нь 6.5 хувиар хүү тооцно. Үндсэн болон хүүгийн төлбөрийг "Эрдэнэс Оюу толгой"-н ирээдүйн ногдол ашгаас суугтана.
Төслийн санхүүжилт	Хувьцаа эзэмшигчдэд ашигтай байх бол хөрөнгө оруулалтыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас босгохыг эрмэлзэнэ.
Дотоодын бүтээгдэхүүн	Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, тээвэр зууч, тээвэрлэлтийн үйлчилгээг тэргүүн ээлжинд Монголын компаниудаас авна.

Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө (UDP)

Нэгдүгээр шатны бүтээн байгуулалтын зардал болон Хөрөнгө оруулалтын гэрээтэй холбоотой Засгийн газраас дэвшүүлсэн асуудлуудыг шийдвэрлэв. Ингэснээр 2013 оноос хойш түр зогсоод байсан гүний уурхайн төслийг дахин эхлүүлэх боломж бүрдэв.

Гарын үсэг зурсан	2015 оны тавдугаар сарын 18
Бүтээн байгуулалтын зардал	Нэгдүгээр шатны бүтээн байгуулалтын төсөв болон бодит зардлын хоорондох зөрүүг тайлбарласан аудитын шалгалтын дүнг баталгаажуулав. Гүний уурхайн бүтээн байгуулалтад жил бүр зарцуулах тойм дүнг тогтоов.
ТЭЗҮ	ТЭЗҮ-ийг боловсруулахад тухайн цаг үеийн тоо баримтад үндэслэсдэг тул тооцоолул нь гүйцэтгэлийн үеийн тооцооллоос зөрж болохыг хүлээн зөвшөөрсөн. Бодит үр дүн тооцооллоос их, бага хамжээгээр зөрөх магадлалтай.
Татварын орчин	Хөрөнгө оруулалтын гэрээний тогтворжуулсан татваруудтай холбоотой заалтуудыг баталгаажуулав. Татвартай холбоотой маргааныг эцэслэв. Тухайлбал, борлуулалтад ногдуулах нөөц ашигласны төлбөрийг хэрхэн тооцохыг.
Өгөөж хуваарилалт	Далд уурхайн ТЭЗҮ-ийн дагуу Засгийн газар "Оюу толгой" төслийн хэрэгжих хугацааны туршид нийт өгөөжийн 53 гаруй хувийг татвар, нөөц ашигласны төлбөр, ногдол ашиг хэлбэрээр хүртэхээр тооцсон болно.
Менежментийн үйлчилгээний төлбөр	Төлбөрийг далд уурхайн бүтээн байгуулалтын үед гурван хувь болгож багасгав.
Санхүүжилт	Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөг гаргав (олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас авах.)

Төслийн товч мэдээлэл

Үе дамжих нүсэр бүтээн байгуулалт

Оюу толгойн 20.8 сая тонн зэс, 23.5 сая унц алтны нөөц бүхий бүлэг орд нь дэлхийн томоохонд тооцогдох зэс-алтны нөөцтэй ордын нэгд зүй ёсоор орно. Одоогоор ил уурхайгаас олборлож байгаа бөгөөд 2020 оноос өндөр агуулга бүхий гүний уурхайгаас хүдэр олборлолт давамгайлна.

Оюу толгойн бүтээн байгуулалтыг шат дараатай хийснээр уурхайн зардлыг удирдаж, санхүүгийн хүндрэлийг даван туулах бололцоотой болох юм. Ингэснээр төслийн үйл ажиллагаанаас олсон орлогоос дараагийн шатны бүтээн байгуулалтын зардлыг санхүүжүүлэх замаар гаднын санхүүжилтийн эх үүсвэрийн дарамтыг багасгадаг. Ил уурхайн үйлдвэрлэлийн бүтээмж хангалттай өндөр хэмжээнд байгаа ч зэс, алтны агуулга бага учир бага зардалтай зэс үйлдвэрлэгч болж, дэлхийд өрсөлдөх боломж хязгаарлагдмал юм. Харин гүний уурхай ашиглалтад орсноор Оюу толгой бага зардалтай зэс олборлогчдын эгнээнд шилжиж, Засгийн газар болон хувьцаа эзэмшигчдийн үр ашиг мэдэгдэхүйц нэмэгдэн зэс, алтны дэлхийн зах зээлийн үнэ хэлбэлзэхэд ч ашигтай ажиллах боломж бүрдэнэ. Түүнчлэн, дэлхийн хэмжээний асар баялаг нөөц нь уурхайн ажиллах хугацааг уртасгаж, жилийн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зэргээр зах зээлийн нөхцөл байдалд тохируулан уян хатан ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зураг 5. Ил болон гүний уурхайн хөгжлийн үе шатууд



Эх сурвалж: Оюу Толгой


Татаж авах

Ил уурхай

"Оюут" орд хүнд даацын машин, хутгуурт ачигч зэргийг ашиглан уламжлалт ил уурхайн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд өрөмдлөг, тэсэлгээ, ачих, тээвэрлэх гэх мэт үе шаттай. Ил уурхайд 24 цагаар буюу нэг ээлж нь 12 цагаар 560 орчим хүн ажилладаг. Өдгөө тус уурхай төлөвлөсөн хэмжээнээс давуулж буюу өдөрт 100 мянган тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

"Үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших зургаан жилийн хугацаанд 500 сая гаруй тонн хүдэр олборлож, хоёр км өргөн, 300 метр гүн ил уурхай бий болов".

Зураг 6. Ил уурхайн үйл ажиллагааны үзүүлэлт




Татаж авах

Эх сурвалж: Туркойз хилл ресурс

Тэсэлсэн чулуулгийг дөрвөн том хутгуурт ачигчаар ачиж, 290 тонны даацтай 28 машинаар зөөдөг бөгөөд эдгээр техник Монголын уул уурхайн салбарт хамгийн томд тооцогддог. Хүнд даацын машин нь хоосон чулуулгийг зөөж зайлуулахаас гадна хүдрийг ил уурхайн хажууд орших анхдагч бутлуур руу зөөх ажлыг мөн гүйцэтгэнэ. Улмаар буталсан хүдрийг 2.7 км урттай туузан дамжуулгаар том ширхэгтэй хүдрийн овоолго руу зөөвөрлөж, дараа нь баяжуулах үйлдвэрт хүргэнэ.


Зураг 7. Ил уурхайн олборлолтын үйл ажиллагаа



Татаж авах

Эх сурвалж: Оюу Толгой

Зураг 8. Баяжуулах үе шат



Эх сурвалж: Оюу Толгой

Татаж авах

Баяжуулах үйлдвэр

Олборлосон хүдэр нь маш бага эрдсийн агуулгатай байдаг. Ил уурхайгаас олборлож буй тонн хүдэрт агуулагдах зэс 5 кг-аас бага, харин алт нь граммыг гурав хуваасны нэгээс ч бага байдаг. Гүний уурхайн олборлолт эхлэхэд эрдсийн агуулга нэмэгдэх боловч борлуулах хэмжээний бүтээгдэхүүн гаргаж авахын тулд тодорхой хэмжээний боловсруулалт хийх шаардлагатай байдаг. Оюу толгойн баяжуулах үйлдвэр нь хүдрээс хаягдал чулуулаг, хольцыг цэвэрлэх боловсруулалт хийдэг. Үүний үр дүнд ойролцоогоор 25 хувийн зэс агуулсан баяжмал гаргана.

Том ширхэгтэй хүдрийг дэлхийд томдоо орох цуваа тээрмээр бутлан баяжуулахад бэлэн болгож гаргана. Тээрэмдсэн хүдрийг үйлдвэрлэлийн дараагийн шат болох хөвүүлэн баяжуулах дамжлага руу шилжүүлж зэс, алт, мөнгийг хөөсөнд наалдуулан ялгаж авна. Уг хөөсийг хөвүүлэн баяжуулах машинаас гарган баяжмал өтгөрүүлэгчид оруулж, илүүдэл усыг нь шавхсанаар зэсийн нунтаг баяжмал гаргаж авна. Гүний уурхайг ашиглалтад оруулахаас өмнө баяжуулах үйлдвэрийг өндөр агуулгатай хүдэр баяжуулах боломжтой болгон шинэчилж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нь нэмэгдүүлнэ.


Гүний уурхай

Ил уурхайтай харьцуулахад эрдсийн өндөр агуулгатай гүний бүлэг орд нь Оюу толгойн ашиг орлогын гол цөм юм. Зэс, алтны өндөр агуулгатай учир Оюу толгойг дэлхийн хамгийн том зэсийн уурхайн нэг болгоно.

Газрын гадаргаас 700 метрийн гүнд орших эдгээр бүлэг ордыг ил уурхайн аргаар олборлох боломжгүй. Эдгээр ордын хүдрийн биет газрын гүнд, тархай байрлалтай учир геотехник болон эдийн засаг талаасаа блокчлох аргаар олборлоход илүү тохиромжтой. Энэ арга нь хүдрийн биетийн хүндийн жинг ашиглан дороос нь бутлан хүдэр буулгуураар цуглуулан авч, туузан дамжуулгаар газрын гадарга дээр гаргана.

Хүдрийг урьдчилан тооцоолсны дагуу хяналттайгаар нурааж авна. “Рио тинто” блокчлон олборлох аргаар мэргэшсэн дэлхийн шилдэг компани бөгөөд тэнд гүний уурхайн технологийн гол хөдөлгөгч хүч гүний уурхайн олборлолтын зураг төсөл, барилга угсралт, үйл ажиллагааны шилдэг технологийг эзэмшсэн дэлхийн түвшний мэргэжилтнүүд ажилладаг. Блокчлон олборлоход эхний хөрөнгө оруулалтын зардал чамгүй өндөр боловч цаашдын үйл ажиллагааны зардлууд нь олборлолтын бусад аргаас харьцангуй хямд байдаг. Үйл ажиллагааны зардал хямд учир бага агуулгатай эрдэс баялгийг ч үр ашигтай олборлох боломж бүрдүүлж байгаа юм.

Зураг 9. “Оюу толгой”-н гүний уурхайн өргөтгөл



Татаж авах

Эх сурвалж: Оюу Толгой

Дэд бүтэц - Буйд газар анх шан татсан эхлэл

Эрчим хүч

Оюу толгойн бүтээн байгуулалт нь эрчим хүчний өндөр хэрэглээтэй бөгөөд энэ нь Монгол Улсын үйлдвэрлэх нийт эрчим хүчний дөрөвний нэгтэй тэнцэнэ. Найдвартай, тогтвортой эрчим хүчний эх үүсвэр нь уул уурхайн үр ашигтай, аюулгүй ажиллагаанд маш чухал учир эрчим хүч нь уурхайн үйл ажиллагааны явцад гарах хамгийн өндөр зардалд тооцогддог. Иймээс “Оюу толгой” компанийн эдийн засгийн үр ашгийн гол түлхүүр стратеги нь найдвартай, хямд эрчим хүчний эх үүсвэр сонгоход оршино.

“Оюу толгой” компани бүтээн байгуулалтын эхний үед барилгын ажлын шахуу хуваарийн шаардлагаар БНХАУ-аас түр хугацаагаар эрчим хүчээ импортлож байна. Дараагийн шатанд Таван толгойд барих гуравдагч талын эзэмших цахилгаан станцын гол худалдан авагч болох зэрэг хувилбарыг Засгийн газартай хамтран судалсаар ирсэн билээ. Гэтэл 2018 оны хоёрдугаар сард Монгол Улсын Засгийн газар “Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах” гэрээг цуцалснаар “Оюу толгой” 2022 он гэхэд дотоодоос эрчим хүч авах гэрээний шаардлага үүссэн юм. Одоогоор тус компани Оюу толгойн уурхайд нүүрсээр ажиллах цахилгаан станц байгуулах өмнөх төлөвлөгөөгөө дахин авч үзэж байна. Энэ шийдэл нь бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн станц барих хувилбараас илүү хурдан, элдэв бэрхшээлгүй байх давуу талтай.

“Эрчим хүч, ус бол зэсийн олборлолтын үйл ажиллагаанд хамгийн чухал хүчин зүйлс юм. Өмнөговь аймагт энэ хоёр хүчин зүйл маш дутагдалтай учир мэргэжлийн өндөр түвшний арга барил, менежмент шаардлагатай”.

Ус хангамж

Зэс баяжуулах үе шатанд ус асар чухал хэрэгцээтэй ч Өмнөговьд ус ховор баялаг юм. Үйлдвэрлэлийн усны хэрэгцээ, нутгийн оршин суугчдын усны хэрэглээг одоо болоод ирээдүйд тэнцвэртэй хангах үүднээс “Оюу толгой” компани дэлхий дээрх усны хамгийн хэмнэлттэй зэсийн уурхайг төлөвлөн ажиллуулж буй. Олборлолтын эхний жилүүдэд ус ашиглалтын хэмнэлтийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж 0.42 шоо метр усаар нэг тонн хүдэр боловсруулж байгаа нь дэлхийн зэсийн үйлдвэрлэлд ашигладаг усны дундаж хэмжээ болох 1.2 шоо метрээс харьцангуй бага үзүүлэлт юм. Оюу толгойн хаягдал усны дахин ашиглалт 85 хувиас өндөр үзүүлэлттэй байна.

“Оюу толгой” компанийн ус ашиглалт нь орон нутгийн иргэдийн ус хангамжид ямар ч сөрөг нөлөө үзүүлэхгүй байх арга хэмжээ авч, уурхайгаас 50 км зайд газрын гүний давхаргын шорвог усны эх үүсвэрийг илрүүлсэн юм. “Оюу толгой” компани уг усны нөөцийг хэрэглэсэн зардлаа компанийн болон хөндлөнгийн хяналт дор төлдөг. Тус компани орон нутгийн иргэдийг аюулгүй, цэвэр, ундны усаар хангах зорилгоор Ханбогд суманд 6.9 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар Цэвэр ус хангамжийн цогцолборыг байгуулсан билээ.

Тээвэр

“Оюу толгой” компани орон нутгийн тээврийн дэд бүтцэд ихээхэн хөрөнгө зарцууллаа. Урьд өмнө нь өмнийн говийн энэ бүс нутагт хатуу хучилттай авто зам, өндөр хүчин чадалтай нисэх буудал байгаагүй. Зэсийн баяжмалыг үр ашигтай, аюулгүй тээвэрлэх үүднээс тус компани БНХАУ-ын хил хүртэл 105 км хатуу хучилттай авто зам байгуулсан юм. Өдгөө уурхайгаас Ханбогд сум хүртэл авто зам тавьж байна. Оюу толгойн уурхайгаас 11 км зайд Улаанбаатараас хүн, бараа материал тээвэрлэх боломжтой орон нутгийн нисэх онгоцны буудал барилаа. Энэ нисэх буудлыг Ханбогд сум орон нутгийн зориулалтаар давхар ашигладаг.

Ажилчдын хотхон

“Оюу толгой” компани аль болох орон нутгийн иргэдээс ажиллах хүчээ хангах бодлого баримталдаг. Гэвч орон нутгийн иргэдийн ур чадвар хангалтгүй учраас уурхайд ажиллах хүч болон гэрээт гүйцэтгэгчдийг бусад газраас авч ажиллуулах зайлшгүй шаардлага үүсдэг. Уурхайн ажилтнуудыг аюулгүй, тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бололцоогоор хангах үүднээс тус компани уурхайн кемпэд орон байраар хангадаг.

Оюу толгойн уурхайд дунджаар 3 мянган үндсэн болон гэрээт ажилчид ажилладаг бөгөөд оргил бүтээн байгуулалтын үед энэ тоо 6 мянга гаруй болно.

Экспортын ложистик, хэрэглэгчид болон маркетинг

“Оюу толгой” компани зэсийн баяжмалаа олон улсын зах зээлд борлуулдаг бөгөөд зэсийг цахилгаан машин, компьютер, агааржуулагч, ухаалаг гар утас зэрэг олон төрлийн бараа үйлдвэрлэхэд ашигладаг. Дэлхийн зах зээлд арвин туршлагатай “Рио тинто” компани “Оюу толгой” компанид маркетинг, борлуулалтын үйлчилгээ үзүүлдэг. Тодруулбал, “Рио тинто” компани шууд нэг удаагийн шууд болон урт хугацааны борлуулалтын гэрээнүүд, ложистик, борлуулалтын хуваарь, борлуулалтын менежментийг хариуцдаг юм. Борлуулалтын үнэ нь олон улсын зах зээл дээрх ханшаар тогтоогдохын зэрэгцээ хайлуулах үйлдвэрт хүрэх тээврийн өртгөөс хамааран харилцан адилгүй үнээр хэрэглэгчдэд хүрдэг.

Зураг 10. Өдөр бүр дунджаар 3 мянган тонн зэсийн баяжмал экспортолдог



$$2\text{тн} \times 14 \times 20 \times 5 = 2,800\text{тн}$$

Баяжмалыг
хоёр тоннын
уутанд савладаг.

Нэг машинд 14
уут баяжмал
ачдаг.

Нэг цуваанд 20
машин явдаг.

Өдөрт 5 цуваа
явдаг.

Өдөрт 2 800
тонн баяжмал
тээвэрлэдэг.

 Татаж авах

Эх сурвалж: Оюу толгой ХХК

Байгаль хамгаалал

Өвөрмөц тогтоцтой говь нутагт байгаль хамгаалал чухал шаардлагатай зүйлсийн нэг юм. “Оюу толгой” компани байгаль орчинд эерэг нөлөөг ахиу үзүүлэх зорилт тавин ажилладаг. Ингэснээр төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг багасгахын зэрэгцээ бүс нутгийн унаган төрхийг хадгалахад бодитой хувь нэмэр оруулж байна. “Оюу толгой” компанийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөнүүдэд эдгээр арга хэмжээг дэлгэрэнгүй тусгасан бөгөөд “Оюу толгой” компанийн албан ёсны цахим хуудсанд нарийвчилсан судалгаа, хяналтын үйл ажиллагаа болон хөндлөнгийн тайлан, тоон мэдээллийн хамт нээлттэй тавьсан байдаг.

Бүс, орон нутгийн хөгжлийн хурдасгуур

Оюу толгойн уурхайг урт хугацаанд амжилттай ажиллахад тухайн орон нутгийн оролцогч талууд чухал үүрэгтэй. Төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, уурхайн хаалтын үе шатанд тус компани зөвхөн хөрш зэргэлдээ сумдад төдийгүй нийт Өмнөговь аймаг болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацааны хувь нэмэр оруулах үүрэг хүлээсэн юм. Байгаль орчинд анхаардгийн нэгэн адил “Оюу толгой” нийгэмд үзүүлэх сайн, муу аливаа нөлөөллийг тооцох, хянах, шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулж хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдалд ч зохицуулан тасралтгүй хэрэгжүүлдэг. Энэ үүргийн биелэлтэд хөндлөнгийн мэргэжилтэн, шинжээчид хараат бус аудит хийж, үр дүнг нь олон нийтэд тайлагнадаг.

“Уул уурхайн компаниуд ажлын байр бий болгох, дотоодын ханган нийлүүлэгчдэд бизнесийн боломж олгох зэргээр эдийн засгийн тогтвортой өгөөжийг бий болгодог бол зарим компани үүнээс ч илүү хувь нэмэр нийгэмд оруулдаг. Орон нутгийн тогтвортой хөгжилд түлхэц болох зорилгоор төслүүдийг санхүүжүүлэх “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-г байгуулан ажиллаж байна.

Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын манлайлал

Үйлдвэрлэлийн бусад салбарыг бодвол уул уурхайд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдэл илүүтэй үүсдэг. Тиймээс “Оюу толгой” ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг эн тэргүүнд тавьж аюулгүй ажиллагааны менежментийн систем, зохих стандартыг баримтлан улам боловсронгуй болгон ажиллаж байна. Үр дүнд нь “Оюу толгой” компани аюулгүй ажиллагааны үзүүлэлтээрээ дэлхийн уул уурхайн салбарын хэмжээнд болон “Рио тинто” группийн дотор хамгийн шилдэгт тооцогдож, тэргүүн туршлагаа түгээсээр байна. Ингэснээр Монгол шиг байгалийн баялгаа ашиглаж эхэлж буй улсад дадлага туршлагатай, хариуцлагатай ажиллах хүчнийг бэлтгэн өгч байгаа хэрэг юм. Тус уурхайн үйлдвэрлэл гүний уурхайд шилжихтэй зэрэгцэн ил уурхайн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ололт, амжилтаа хуваалцах, хадгалахыг зорин ажиллаж байна.


ОЮУ ТОЛГОЙН ЗЭСИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Хүдрээс метал хүртэл

Оюу толгойн уурхай нь 17 тонн чулуулгаас

29 кг зэс

гарган авдаг. Үүгээр нэг “Toyota Prius” машин бүтээдгийг та мэдэх үү?



17 ТОНН

Ил уурхайгаас гаргаж
авсан материал



12 ТОНН

Ил уурхайгаас
гарсан хаягдал



5 ТОНН

Баяжуулах үйлдвэр
рүү зөөсөн хүдэр

ИЛ УУРХАЙ



1.7 ТОНН

Гүний уурхайгаас ухаж
гаргасан материал



—

Гүний уурхайгаас маш бага
хаягдал чулуулаг гардаг



1.7 ТОНН

Хүдрийг баяжуулах
үйлдвэр рүү зөөнө

ГҮНИЙ УУРХАЙ

Ил уурхайн тоон үзүүлэлтүүд нь 2016 оны бодит гүйцэтгэл бөгөөд гүний уурхайн өгөгдлүүд нь 2026-2030 оны таамаглал болно.

Хүдрийг хаягдалгүй
боловсруулж, өндөр агуулгатай
зэс гаргаж авна гэдэг нь нэг
Toyota Prius машин бүтээхэд
шаардагдах 29 кг зэсийг гарган
авахын тулд

90% бага


материал олборлоно гэсэн үг.

ИЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



1.3 гр алт

Хуримын
бөгжний гуравны
нэг



29 кг зэс

Prius машины
цахилгааны утас



6.4 гр мөнгө

Мөнгөн зоосны
зургааны нэг



122 кг

Зэсийн
баяжмал

БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР



92 кг


Зэсийн
баяжмал

ГҮНИЙ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



0.6 гр алт

Хуримын
бөгжний
зургааны нэг



29 кг зэс

Нэг "Toyota
Prius"-ийн
цахилгааны утас



5.6 гр мөнгө

Мөнгөн
зоосны
долооны нэг

Гүний уурхайн
олборлолтод шилжсэнээр
үйлдвэрлэлийн үйл
ажиллагааны нэгжийн
зардал мэдэгдэхүйц
буурах бөгөөд улмаар
татвар, роялти буюу
ашигт малтмалын нөөц
ашигласны төлбөр, ногдол
ашиг нэмэгдэнэ.

Хөрөнгө оруулалтын зардал, санхүүжилтийн стратеги

Хөрөнгө оруулалтын зардал гэж юу вэ?

Хөрөнгө оруулалтын зардал нь аливаа төслийг амжилттай хэрэгжүүлэх, эсвэл нураах гол хүчин зүйл болдог. Тиймээс хөрөнгө оруулагчид энэ зардлыг аль болох зөв тооцох, бууруулахыг эрмэлздэг. Үүний тулд уул уурхайн компаниуд төсөлд хөрөнгө оруулах эцсийн шийдвэр гаргахын өмнө удаа дараа судалгаа хийдэг. Судалгааны үе шат бүр нь төслийн төсөвт өртгийг улам тодорхой болгох, улмаар төслийн эрсдэлийг багасгах зорилготой.

“Уул уурхайн төслийн ашигтай ажиллах гол түлхүүр нь хөрөнгө оруулалтын зардлын хяналт юм. Хөрөнгө оруулалтын зардал өсөх нь хөрөнгө оруулагчид болох “Рио тинто”, “Туркойз хилл ресурс”, Монгол Улсын Засгийн газарт ямар ч ашиггүй учраас зардлыг хянах талаар санал нэгдэж ажилладаг”.

Эхний шатны судалгаануудыг +/-50 хувийн нарийвчлалтай явуулахыг зорьдог. Харин төслийн ТЭЗҮ-ийг бүрэн боловсруулах үе шатанд +/- 15 хувийн нарийвчлалтай болсноор тухайн төслийг итгэл дүүрэн хэрэгжүүлэх шийдвэр гаргах боломжийг хөрөнгө оруулагчдад олгох хэрэгтэй. Хөрөнгө оруулах шийдвэр гарсны дараа өндөр өртөгтэй инженерингийн ажил хийгддэг учир хөрөнгө оруулалтын тооцоог яв цав гаргах боломжгүй юм. Хянах боломжгүй олон хувьсах зардал бүтээн байгуулалтын явцад гарч, төслийн төсөвт өртөгт нөлөөлдөг. Жишээ нь, ажлын цар хүрээ, хуваарь өөрчлөгдөх, бараа материал, ажиллах хүчний зардал хэлбэлзэх, мөн валютын ханшийн хэлбэлзэл зэрэг шууд бус хүчин зүйлс гэх мэт. Иймээс төсөвт өртгийн тооцоо нь бодит зардлаас зөрдөг. Үүний нэгэн адилаар хөрөнгө оруулалтын зардал нь төслийн ашигт ажиллагаанд асар их нөлөөлдөг болохоор ТЭЗҮ-ийн судалгаагаар төслийг өгөөжтэй байна гэсэн баталгааг ямар ч хувьцаа эзэмшигчдэд гаргадаггүй. Өөрөөр хэлбэл, энэ нь төсөвт өртгийн нарийвчилсан тооцоо болохоос ирээдүйд өгөөжтэй байна гэсэн амлалт биш юм.

Монгол Улсын түүхэн дэх хамгийн их хэмжээний хөрөнгө оруулалтыг “Оюу толгой” төсөлд хийж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын нийт зардал нь Монгол Улсын өнөөгийн ДНБ-ээс хавьгүй илүү юм. Ийм том цараатай төслийн хөрөнгө оруулалтын зардлыг хэдийгээр нарийвчлан тооцсон ч бодит зардал нь хэдэн зуун сая ам.доллараар зөрөх нь бий. Хөрөнгө оруулалтын нийт зардлыг бүтээн байгуулалтын хоёр үе шатанд хувааж байна. 2010-2013 онд хамаарах эхний шатанд Ил уурхай, Баяжуулах үйлдвэр, Гүний уурхайн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил болон дагалдах нийт дэд бүтцийн ажил хамаарна. Харин хоёрдугаар үе шатанд Гүний уурхайн өнөөгийн бүтээн байгуулалтын ажил, нэвтрэх ам, агааржуулалтын босоо ам, Баяжуулах үйлдвэр, дэд бүтцийг өргөтгөн, сайжруулах ажил багтана.

Бүтээн байгуулалтын нэгдүгээр үе шатны зардал

Монгол Улсын Эрдэс баялгийн зөвлөлийн хүлээн авсан 2009 оны Оюу толгойн ТЭЗҮ-ийн судалгаанд нэгдүгээр үе шатны бүтээн байгуулалтыг НӨАТ, менежментийн үйлчилгээний төлбөрийг тусгаж оруулалгүйгээр 5.1 тэрбум ам.долларын өртгөөр дөрвөн жилийн дотор гүйцэтгэнэ гэж заажээ. Гэвч Хөрөнгө оруулалтын гэрээг батлах, холбогдох гол гол зөвшөөрөл авах ажил удааширснаас бүтээн байгуулалтын ажил 2010 оны 3 дугаар сард л эхэлсэн юм. Ийнхүү хугацаа алдсанаас учрах санхүүгийн нөлөөллийг багасгах зорилгоор “Оюу толгой” ХХК бүтээн байгуулалтын төлөвлөгөөгөө шахан ажиллаж, гурван жил хүрэхгүй хугацаанд төслийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгасан юм.

Бүтээн байгуулалтын ажлын явцад төсөвт өртгийн тооцоот зардлыг бага багаар зарлагдаж ирэв. Эрчим хүчний хангамж, газрын нөхцөл байдал, бүтээн байгуулалтын хурдасгасан хуваарьт шилжсэн, зарим нэг зөвшөөрөл хойшилж байсан зэргээс зардлын зөрүү их гарлаа. Мөн ТЭЗҮ-ийг баталсны дараа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орж, “Оюу толгой” ХХК барилга, бүтээн байгуулалтын ажилд ашигласан зарим материалын НӨАТ-ын буцаалтаа авах боломжгүй болов. Хөрөнгө оруулалтын зардал нэмэгдсэнээр ийнхүү Монгол Улсын Засгийн газар татвар авах замаар дангаараа өгөөж хүртэж, харин бусад хөрөнгө оруулагчдаас урьдчилж гарах зардал нэмэгдсэн юм.

Зураг 11. Төслийн нэгдүгээр үе шатны он цагийн товчоон



Татаж авах

Эх сурвалж: "Эрго стратеги групп"

"Оюу толгой" төслийн нэгдүгээр үе шатыг хуваарьт хугацаанаас нь өмнө хөрөнгө оруулагчдын баталсан төсвийн хүрээнд амжилттай хэрэгжүүлснээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татвар, хураамжуудыг Засгийн газарт төлөвлөснөөсөө эрт төлж эхлэв".

Бүтээн байгуулалтын ажлын явцад зардлын дүн шинжилгээ, төсөвт тооцооны өөрчлөлтүүдийг "Оюу толгой" ХХК-ийн ТУЗ болон "Эрдэнэс Оюу толгой" компанид тогтмол хүргүүлэн танилцуулж байв. Засгийн газар болон бусад хөрөнгө оруулагчдын төлөөлөл орсон ТУЗ төсөвт тооцоо бүрийг санал нэгтгэйгээр баталж ирсэн юм. Хэдийгээр бүтээн байгуулалтын үе шатанд тодорхой хүчин зүйлсийн улмаас инфляци өссөн зэрэг хүчин зүйлс нөлөөлж байсан хэдий ч бүтээн байгуулалтын эцсийн зардал нь дээрх батлагдсан төсвүүдийн хүрээнд байж, хэтрүүлэн зарцуулсан зүйл гараагүй болно. Төслийн нэгдүгээр үе шатны зарцуулалтад дотоод болон хөндлөнгийн аудитын шалгалт хийсний аль аль нь баталсан төсвийн дагуу зардлыг зарлагдсаныг баталсан юм. Нийт зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, тооцоолсон болоод бодит зардлын хоорондох зөрүү үндэслэлтэй болохыг Монгол Улсын Засгийн газар ч мөн хүлээн зөвшөөрсөн билээ.


Зардалд нөлөөлсөн дээрх хүчин зүйлс байсан хэдий ч нэгдүгээр үе шатны зардлыг 2009 онд батлагдсан ТЭЗҮ-д заасан дүнгээс 14 хувиар өссөн дүн буюу 6.49 тэрбум ам.доллараар хязгаарласан бөгөөд энэ нь ТЭЗҮ-ийн тооцооны нарийвчлалын босго үзүүлэлтээс хэтрээгүй үзүүлэлт юм (дээрх дүнд НӨАТ болон менежментийн үйлчилгээний төлбөр тус тус багтсан болно). Тухайн үед уул уурхайн салбарын хэмжээнд энэ зөрүү дунджаар 60 хувьд хүрэх нь түгээмэл байсантай харьцуулахад энэ нь харьцангуй бага үзүүлэлт байлаа. "Оюу толгой" компани ийнхүү бүтээн байгуулалтын ажлаа хугацаандаа дуусгасан нь тухайн салбартаа ховор тохиолдол байв. Тус салбарын тооцоо, судалгаанаас үзэхэд 2013 онд уул уурхайн бусад төсөл дунджаар 2.5 жилийн хоцрогдолтой байсан юм.

Нэгдүгээр үе шатны хөрөнгө оруулалтын зардлын санхүүжилт

Өнгөрсөн хугацаанд Оюу толгойн хөрөнгө оруулалтын зардлыг хувьцаа эзэмшигчдээс нь бэлэн мөнгө татаж санхүүжүүлж ирсэн юм. Төслийн бүтээн байгуулалтын эхэн үед санхүүжилтийн үүнээс өөр сонголт/хувилбар ч байсангүй. Хөрөнгө оруулагчдын санхүүгийн дэмжлэггүйгээр төслийг хэрэгжүүлэх боломжгүй байсан нь эндээс харагдана.

Бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө бараг нэг тэрбум ам.долларыг хайгуул, судалгаа, үнэлгээний ажилд зарцуулаад байлаа. Үүнийг "Айвенхоу майнз" компани (одоогийн "Туркойз хилл ресурс") хувьцаа эзэмшигчдээс эзлэх зарчмаар санхүүжүүлсэн болно. Энэ нь хувьцаа эзэмшигчид бэлэн мөнгийг төсөлд урьдчилж өгөөд тодорхой хугацааны дараа тохирсон хүүтэйгээ буцааж авна гэсэн үг юм.

Зураг 12. Зэсийн бусад уурхайн ТЭЗҮ-ийн анхны төсөвт өртгийн тооцоотой харьцуулахад хөрөнгө оруулалтын бодит зардлын өсөлтийг хувиар илэрхийлсэн байдал



Эх сурвалж: АМЕ эрдсийн эдийн засаг

Татаж авах

Бүтээн байгуулалтын нэгдүгээр үе шатыг дээрхтэй ижил зарчмаар санхүүжүүлсэн. “Оюу толгой” компанийн хувьцаа эзэмшигч “Туркойз хилл ресурс” болон “Рио тинто” компаниуд 2010 оноос хойш “Оюу толгой” төслийг өөрийн хувьцаагаар болон хувьцаа эзэмшигчдийн зээлээр санхүүжүүлж ирсэн юм. Энэ зээлийн жилийн хүүг LIBOR дээр нэмэх нь 6.5 хувь байхаар тогтоосон. Энэ нь шинэ тутам хөгжиж буй зах зээл дээр уул уурхайн шинэ төслийг тэгээс эхлүүлж, хувьцаагаар санхүүжүүлж байгаа нөхцөлд тун боломжийн хүү юм. 2013 оны эцэс гэхэд зургаан тэрбум гаруй ам.долларыг хувьцаа эзэмшигчдийн зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь “Рио тинто” компанийн хувьд бусад улс орон дахь төслүүдтэй нь харьцуулахад хамгийн их хөрөнгө оруулалт болсон юм.

Засгийн газрын эзэмшил, оролцоо


Хөрөнгө оруулалтын гэрээ, Нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ, Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө зэрэг баримт бичигт Монгол Улсын Засгийн газар болон хөрөнгө оруулагчид “Оюу толгой” төслийг санхүүжүүлэх стратегийг харилцан тохиролцсон билээ. Эдгээр гэрээнд Оюу толгойн 34 хувийг Монгол Улсын Засгийн газар эзэмших ба Хөрөнгө оруулалтын гэрээний эхний 30 жилийн дараа эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлэх сонголтыг Монгол Улсын Засгийн газарт олгосон тодорхой заалтыг тусгасан билээ.

Монгол Улсын Засгийн газар Оюу толгой дахь хувь эзэмшлээ төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компаниар дамжуулан хэрэгжүүлдэг бөгөөд уг компанийг Монгол Улсын стратегийн ач холбогдолтой ордуудыг ашиглаж, эзэмшихэд засгийн газрын ашиг сонирхлыг хэрэгжүүлэн оролцох зорилгоор байгуулжээ. “Эрдэнэс Монгол” компани 2012 онд өөрийн охин компани “Эрдэнэс Оюу толгой” компанийг байгуулсан бөгөөд тус компани Засгийн газрын өмнөөс Оюу толгойд хувь эзэмшиж, зохицуулах үүрэгтэй оролцож буй.

Хэдийгээр Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаар Монгол Улсын Засгийн газар төслийн 34 хувийг эзэмшсэн боловч нэгдүгээр үе шатны хөрөнгө оруулалтын зардалд мөнгөн хувь нэмэр оруулах үүрэг хүлээгээгүй. Харин “Туркойз хилл ресурс” компани төслийн нэгдүгээр үе шатны нийт хөрөнгө оруулалтын зардлыг дангаараа гаргасны дотор Засгийн газарт ногдох хувь хэмжээ ч багтсан юм. Монгол Улсын Засгийн газар энэ зээлийг компанийн ирээдүйд олох ашгаас хүүгийн хамтаар буцаан төлөх нөхцөлтэй. Монгол Улс тухайн үед өөрт ногдох зардлыг санхүүжүүлэх, зээлээр хөрөнгө мөнгө босгох боломжгүй байсан учир Монгол Улсын Засгийн газрын оролцоог хангахын тулд үүнээс өөр гарц байсангүй. Хөрөнгө оруулалтын зээлийн хүүгийн төлбөр нь “Оюу толгой” компаниас Засгийн газарт төлөх татвар, нөөц ашигласны төлбөрт ямар нэг нөлөө үзүүлэхгүй.

“Олон улсын хувьцаа эзэмшигчид Засгийн газрын хувь эзэмшилд ногдох хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн бөгөөд “Оюу толгой”-н ирээдүйд олох орлогоос эргэн төлөлтийн эх үүсвэр бүрдэх юм”.

Зураг 13. Гүний уурхайн бүтээн байгуулалтад төлөвлөсөн зардлууд (2016 оны ТЭЗҮ, тэрбум ам.доллараар)



Татаж авах

Эх сурвалж: "Туркойз хилл ресурс" компани

Засгийн газраас эргэн төлөх хөрөнгө оруулалтын зээлийн хүүг LIBOR+6.5% гэж тохирсон нь "Туркойз хилл ресурс" компаниас уурхайг санхүүжүүлэхэд нь "Оюу толгой" компанид олгосон хувьцаа эзэмшигчдийн зээлийн хүүтэй ижил юм. Энэ хүү нь мөн Засгийн газрын урт хугацааны бондын хүүтэй өрсөлдөхүйц түвшинд байлаа. Монгол Улсын Засгийн газар санхүүжилтийн багц хөтөлбөр хэрэгжүүлэхээр ОУВС-тай тохиролцоонд хүрснээр ерөнхий хандлага сайжирч Монгол Улсын Засгийн газар таатай хүүтэй бонд гаргаад удаагүй байгаа ч нөхцөл байдал байнга ийм байх баталгаа байхгүй. Жишээ нь, Монгол Улсын Засгийн газрын 2016 онд гаргасан таван жилийн хугацаатай бондын жилийн өгөөж нь 11 хувь байлаа. Харин "Туркойз хилл ресурс" компани хүүгийн хэмжээг урьдчилаад хөдөлгөөнгүй тогтмол байхаар тогтоосноор энэ тогтворгүй байдлыг арилгасан юм. Засгийн газар үүнээс хямд эх үүсвэрээс санхүүжилт босгож чадвал зээлээ хэдийд ч буцаан төлөх боломжтой.

Хоёрдугаар үе шатны үйл ажиллагааны зардал

"Оюу толгой" компани анхандаа төслийн нэгдүгээр үе шатны бүтээн байгуулалтаа дуусмагц Гүний уурхайн бүтээн байгуулалтыг даруй эхлүүлэхийг зорьсон билээ. Гэвч Гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотой үүссэн маргааны улмаас эл төсөл "Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө"-нд 2015 онд гарын үсэг зурах хүртэл зогссон юм. Гүний уурхайн бүтээн байгуулалтын зардал 2009 оны үеийнхээс өссөн, мөн Ил уурхайн зэс болон алтны агуулга нь тооцоноос бага байсан зэргээс үүдэн "Оюу толгой" компани гүний уурхайн бүтээн байгуулалтаа үйл ажиллагааны орлогоороо санхүүжүүлэх чадамжгүй болсон юм. Үүнээс үүдэн ТЭЗҮ-ийг 2015 онд, хөндлөнгийн мэргэжлийн тайланг 2016 онд тус тус шинэчлэхдээ Гүний уурхайн хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг 5.3 орчим тэрбум ам.доллар болно гэж тооцоолсон байна.

Гүний уурхайн бүтээн байгуулалтын төслийн санхүүжилт

Нэгэнт Ил уурхайн үйл ажиллагааны орлогоор Гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх боломжгүй нь тодорхой болсон учир "Оюу толгой" компани гадны санхүүжилтэд найдахаас өөр аргагүй болсон юм. Ер нь ийм хэмжээний Ил болон Гүний уурхайн үйл ажиллагааг нэгэн зэрэг дангаараа санхүүжүүлнэ гэдэг ямар ч компанид хэтэрхий ахадсан хэрэг билээ. Нэгдүгээр үе шат дуусахад хэдийнэ долоон тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулаад байсан хувь эзэмшигчид хоёрдугаар шатны санхүүжилтийг арилжааны банкуудаас зээл авч шийдэхийг зорьсон юм.

Энэ нөхцөлд банкнаас санхүүжилт хүсэх этгээд нь "Оюу толгой" ХХК болов. Банк "Оюу толгой" компанийн мөнгөн урсгалын чадамж дээр тулгуурлан зээл олгох бөгөөд хөрөнгийн баталгаа шаардана. Энэ бол олон улсын банкуудын "Оюу толгой" шиг том төсөлд олгодог урт хугацаатай, бага хүүтэй зээлийн нийтлэг шаардлага учир нийт хувьцаа эзэмшигчид бүгд хүлээн зөвшөөрсөн юм. Банкны санхүүжилт нь төслийн хувьцаа эзэмшигчид, ялангуяа Монгол Улсын Засгийн газрын хувь эзэмшилд ямар ч нөлөө үзүүлэхгүй.

“Банкны санхүүжилт “Оюу толгой” компанийн нийт зардлын санхүүжилтийг бууруулав. Яагаад гэвэл, олон улсын банк болон бусад зээлдэгчийн өрсөлдөөний дүнд зээлийн өртөг аяндаа буурсан. Мөн үүгээр Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд олон улсын зүгээс итгэж буйг нотлон харуулсан юм”.

2015 онд хөрөнгө оруулахаар шийдсэн 4.4 тэрбум ам.долларын санхүүжилтийн багцыг олон улсад нэр хүнд бүхий банкууд, экспортын агентлагууд, олон улсын санхүүгийн хэд хэдэн институтын нэгдсэн консорциум санхүүжүүлсэн билээ. Эдгээр байгууллагын итгэл найдвар дэлхийн санхүүгийн зах зээл дээрх Монгол Улсын нэр хүндийн илэрхийлэл болсон юм. Энэ нь уул уурхайн нэг төсөлд олгосон дэлхийн хамгийн том санхүүжилт болон түүхэнд бичигдсэн юм.

Ийм хэмжээ, нөхцөлтэй зээл авч чадсан нь “Оюу толгой” компанид төдийгүй Монгол Улсад итгэх итгэлийг олон улсын тавцанд өсгөж, Монголын үндэсний компаниуд гаднын томоохон банкуудтай хамтран ажиллах үүд нээгдсэн юм. Мөн Монгол Улсын ирээдүйд гаргах бондын үнэлгээнд эерэг нөлөө үзүүлж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулан гадаад санхүүжилтийн эх үүсвэрийн зардлыг бууруулав.

Банкны санхүүжилтийн хүү LIBOR+6% байгаа нь “Оюу толгой” компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдийн санхүүжүүлсэн зээлийн хүүгээс бага юм. Тиймээс банкны зээлээр хувьцаа эзэмшигчдийн зээлийг буцааж төлсөн байна. Оюу толгойн Гүний уурхайн бүтээн байгуулалтын явцад “Туркойз хилл ресурс” компаниас жил бүр хувьцаа эзэмшигчдийн зээлийг дахин татан авч, тухайн жилийн зардлыг санхүүжүүлдэг. Зээлийн ийм менежмент хийснээр “Оюу толгой” компанид шаардлагатай зээлийн хэмжээ өөрчлөгдөхгүй, харин төлөх хүүгийн хэмжээ багасч буй хэрэг юм. Зээлийн зардлын хүү ийнхүү буурснаас үүсэх санхүүгийн өгөөжийг Монголын Засгийн газар болон бүх хувьцаа эзэмшигчид хүрхүү байгаа.

Банкнаас олгосон бага хүүтэй зээлд “Рио тинто” компанид төлөх 1.9 хувийн төлбөр орох бөгөөд Рио тинто нь Гүний уурхайн өргөтгөлийн ажлыг дуусгана гэсэн санхүүгийн баталгааг зээлдэгчдэд гаргасан юм.

Мөн эхний 4.4 тэрбум ам.долларын санхүүжилтэд зээлдэгчид нэмж 1.6 тэрбум хүртэлх ам.долларыг Оюу толгойн Гүний уурхайн ажлыг дуусгахад зориулан зээлэхээр урьдчилан зөвшөөрсөн болно. Ил уурхайгаас олборлож байгаа зэс, алтны агуулга нь тооцож байснаас бага байгаа учир нэмэлт зээл авах шаардлагатай болж байгаа юм. Түүнчлэн “Оюу толгой” компани эрчим хүчний хэрэгцээгээ 2022 он гэхэд дотоодоос хангах тухай Засгийн газрын саяхан гаргасан шийдвэрээр “Оюу толгой” компани цахилгаан станц барихад зориулан хөрөнгө оруулалт хийх шаардлагатай болсон тул нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ улам нэмэгдлээ. Хувьцаа эзэмшигчид банкны энэхүү санхүүжилтээс өөр зээлийн эх үүсвэр шаардлагагүй гэж үзэж байгаа болно.

Хөрөнгө оруулалтын зээлийн үр дүнд Монгол Улсын Засгийн газар төслийн нэгдүгээр үе шатанд шууд мөнгөн хөрөнгө гаргах хатуу үүрэг хүлээгээгүйн адил энэхүү банкны санхүүжилтийн үр дүнд Гүний уурхайн бүтээн байгуулалтад ч мөн адил өр зээл тавилгүйгээр хувь эзэмшлээ баталгаажуулсан юм. Гүний уурхайн ашиглалтад орж, зэсийн баяжмал үйлдвэрлэвэл “Оюу толгой” компани ашигтай ажиллаж эхэлнэ. Энэ үеэс эхлэн Засгийн газар өөрийн ногдол ашгийг авах бөгөөд түүнээсээ “Туркойз хилл ресурс” компанид өглөгөө буцаан төлнө. Зээл, зээлийн хүүгээ бүрэн төлж барагдуулснаар Засгийн газар ногдол ашгаа бүрэн авч эхэлнэ.

Зураг 14. Олон улсад нэр хүнд бүхий санхүүжүүлэгчдийн консорциум “Оюу толгой” төслийг санхүүжүүлж буй.



САНХҮҮЖИЛТ БА МӨНГӨНИЙ УРСГАЛ

Хөрөнгө, зэс, бэлэн мөнгөний урсгал

Монгол Улсын
Засгийн газар

“Оюу толгой” төслийн бүтээн байгуулалтын ачаар урьд хожид байгаагүй хэмжээтэй гадаадын хөрөнгө оруулалт Монголд орж ирэв. Энэ хөрөнгө оруулалт нь монголчуудын хэдэн үеэрээ хүртэх өгөөжийг бий болгох учиртай.

Монгол Улсын
арилжааны банкуудМонголын ханган
нийлүүлэгчид

82%

Монгол ажиллах
хүч

95%

Оюу толгойн уурхай ба
үйлдвэрОлон улсын ханган
нийлүүлэгчид

18%



Гадаад ажиллах хүч

5%



Хөрөнгө оруулагчид



Зээлдүүлэгчид

12

тэрбум

ам.долларын хөрөнгө
оруулалт: Нэг,
хоёрдугаар үе шат



Худалдан авагчид зээлдүүлэгчдийн шаардлагын дагуу олон улсын банкаар төлбөрөө хийнэ.



Засгийн газрын өөрийн хөрөнгийн эргэн төлөлт

Засгийн газар ногдол ашиг авч эхэлмэгц өөрийн эзэмшлийн 34 хувьд ногдох зээлийг хүүтэй нь төлж эхэлнэ. Төлж дууссаны дараа "Эрдэнэс Оюу толгой" компани ногдол ашгаа шууд хүртэж эхэлнэ.



Хувьцаа эзэмшигчдийн зээлийн эргэн төлөлт ба ногдол ашиг

Үйл ажиллагааны ашгаас хувьцаа эзэмшигчдийн зээлийг эргэж төлнө. Зээлийг бүрэн төлсний дараа үйл ажиллагааны ашиг ногдол ашиг байдлаар хуваарилагдана.



Төслийн санхүүжилтийн эргэн төлөлт

Гүний уурхайн бүтээн байгуулалтад зориулан авсан банкны зээлийг 15 жилийн хугацаанд эргэн төлнө.




Төслийн ач холбогдол: Эдийн засгийн нөлөө, үнэ цэнэ

“Оюу толгой” компанийн эдийн засгийн ач холбогдлыг үнэлэхдээ нягтлан бодох бүртгэлийн ашиг орлогын хуваарилалтад анхаардаг тал бий. Гэвч энэ нь бодит байдал дээр тухайн компанийн нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн өчүүхэн хэсэг юм. Үнэн хэрэгтээ Монгол Улс өгөөжийн салаа урсгал бүрээс бодитой үнэ цэнэ хүртэж байна. Энэ үнэ цэнэ нь зөвхөн татвар, хураамж, төлбөрөөр хязгаарлагдахгүй, харин цалин хөлс, ханган нийлүүлэгчдийн төлбөрүүд, зээлээ төлж буй үйл ажиллагааны ашиг, хуваарилагдах ногдол ашиг зэргээр тодорхойлогдоно. Цаашлаад энэ үнэ цэнэ нь эдийн засагт хэд дахин үржигдэж тооцогддог.

Эдийн засагт оруулж буй хувь нэмрийг хэрхэн хэмждэг вэ?

Төслийн эдийн засгийн хувь нэмрийг тодорхойлох нэг арга бол жилийн орлогыг тооцож, орлогын бүрдэл хэсэг бүрийг тодорхойлох явдал юм. Орлого нь тухайн жилийн үр дүнг маш энгийн, тодорхой илэрхийлж, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг харьцуулах боломжийг хэмжигдэхүйц байдлаар харуулдаг.

Зураг 15: Оюу толгойн уурхай ашиглалтын хугацаандаа эдийн засагт үзүүлэх нөлөө, өгөөж.



Эх сурвалж: "Эрго стратеги групп"

Татаж авах

Нийт орлогын эдийн засагт үзүүлэх нөлөө нь дараах хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Нэгдүгээрт, уурхайн үндсэн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай худалдан авсан бараа үйлчилгээ. Тухайлбал, эрчим хүч, химийн бодис, механик эд ангиуд, ачааны машины дугуй гэх мэт. Эдгээрийг дотоодоос худалдан авахад төлбөр нь эдийн засгийн хөдөлгөгч болдог. Хоёрдугаарт, нэмүү үнэ цэнэ/өртөг. Ажилчдын цалин, Засгийн газарт төлөх төлбөрүүд, хөрөнгө оруулагчид болон санхүүжүүлэгчдийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн зардал, ногдол ашиг ирээдүйн хөрөнгө оруулалтад зориулан хуримтлуулсан ашиг гэх мэт компанийн үйл ажиллагаанаас үүсч буй үнэ цэнийн нийлбэрээр нэмүү үнэ цэнэ/өртөг нь тодорхойлогдоно. Хувийн болон төрийн компаниудын ийм нэмүү үнэ цэнийн/өртгийн нийлбэрээр ДНБ-ийг хэмждэг. ДНБ нь улсын эдийн засгийн үндсэн хэмжүүр юм.

Эдийн засгийн бусад өгөөж

Нэмүү өртгийг тооцоходоо төслийн бүтээн байгуулалт зэрэг уурхайн олборлолтын үйл ажиллагааг эхлэхээс өмнөх ажлын үзүүлэлтүүдийг тусгадаггүй гэдгийг тэмдэглэх ёстой. "Оюу толгой" төслийн хувьд энэ нөлөөлөл нь нийт 11.8 тэрбум ам.доллараар хэмжигдэх хоёр үе шаттай бүтээн байгуулалтын ажлаар илэрхийлэгдэж байна. Мөн түүнчлэн хоёрдугаар үе шатны бүтээн байгуулалтын хугацаанд 2.8 тэрбум ам.долларын урсгал капитал зардал гарах юм. Эхний шат нь 2010-2013 онд өрнөж, Ил уурхай болон Баяжуулах үйлдвэрийг байгуулахад ойролцоогоор 6.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан юм. Харин хоёр дахь шат буюу урт хугацааны бүтээн байгуулалтын ажил нь 2016 онд эхэлж 2027 он хүртэл үргэлжлэх бөгөөд үүнд 8.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдана. Үүнээс хойших засвар үйлчилгээ, уулын төлөвлөгөө зэрэг нь тухайн үедээ нэмэлт хөрөнгө оруулалт шаардах боловч өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоосоо санхүүжүүлнэ.

Бүтээн байгуулалтын энэ зардал ханган нийлүүлэлт болон ажил эрхлэлтээр дамжин дотоодын эдийн засагт нэмэлт өгөөжийн боломж бий болгодог. Бүтээн байгуулалтын үе богинохон ч ажиллах хүчний тоо нь уурхайн ашиглалтын үе шатнаас хавьгүй илүү байдаг.

Барилга, бүтээн байгуулалтын үеийн худалдан авалт ч уурхайн ашиглалтын үеэс эрс ялгаатай. Тонг төхөөрөмж, машин техник зэрэг нэг удаагийн үлэмж их худалдан авалтыг дотоодоос ханган нийлүүлэх боломж хомс байдаг хэдий ч бүтээн байгуулалтын ажлын цар хүрээ нүсэр учир бусад худалдан авалтыг зонхилон дотоодоос бүрдүүлэх бүрэн боломжтой.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжуулан улс орнууд эдийн засгийн чадавхиа өсгөн бүтээмж болон өрсөлдөх чадвараа нэмэгдүүлдэг. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалт нь тухайн улсад бизнес эрхлэхэд таатай гэсэн дохиог олон улсын бусад хөрөнгө оруулагчдад өгдөг. “Оюу толгой” төслөөс гарах бусад эерэг үр дүн бол үе дамжин бий болох ажлын байр, ажиллагсдад дэлхийн түвшний мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх, шинэ дэд бүтэц байгуулах, нийгмийн бусад хөрөнгө оруулалт гэх мэт зүйл юм. Шууд авах албан татвараас гадна Засгийн газар байгууллагын төлөх хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал, худалдан авалттай холбоотой НӨАТ, ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой бусад татвар зэрэг шууд бус татваруудаар орлогын эх үүсвэр бүрдүүлдэг. Мөн түүхий эдийн экспорт нь улсын төлбөрийн балансын хэмжээг томруулж гадаадын бараа, үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлснээр импортыг өсгөдөг нь макро эдийн засгийн түвшинд гарч буй бас нэгэн үр дүн юм.

“Монгол Улс татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, цалин хөлс, ханган нийлүүлэгчдэд төлж буй төлбөрүүд, үйл ажиллагааныхаа ашгаар хөрөнгө оруулалтын зээлийг төлөх, ногдол ашиг хуваарилах зэргээр өгөөжийн салаа урсгал бүрээс бодитой өгөөж хүртдэг”.

Нэмүү үнэ цэнийг/өртгийг тооцох нь

Төслийн үр ашгийн дүн шинжилгээнд ашигласан суурь мэдээллийг “Оюу толгой” компаниас авлаа. Дүн шинжилгээ нь Гүний уурхайд илэрсэн нөөцийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үр ашигтай олборлоход шаардагдах нэмэлт хөрөнгө оруулалтын таамаглалд суурилсан байна. Хэрэв энэ тооцоолол амьдрал дээр амжилттай хэрэгжвэл уурхайн ашиглалтын хугацаа дараагийн зуун хүртэл үргэлжлэх боломжтой. Мөн дүн шинжилгээнд ашигласан бүтээгдэхүүний үнийг тооцохдоо зэс 3.04 ам.доллар/фунт, алт 1,305 ам.доллар/унц, мөнгө 19.92 ам.доллар/унц, молибден 9 ам.доллар/фунт гэсэн бие даасан 11 банк, шинжээчдийн хэтийн таамаглалын/тооцооллын дунджийг ашиглав. Эдгээр үзүүлэлт болон тайланд тусгасан санхүүгийн бусад өгөгдлүүдийг ам.доллараар илэрхийлэв. Нэмэгдсэн өртгийн жилийн тооцооллыг гаргахдаа уурхайн ашиглалтын хугацааг 2018-2100-аад оны эхэн үе гэж тооцов.

Орлогын таамаглалыг уурхайн төлөвлөгөө болон ашигт малтмалын агуулгаас хамааран жилээс жилд харьцангуй хэлбэлзэлтэй тооцлоо. Иймээс бодит орлого нь зарим жилд төлөвлөсөн орлогоос давах, эсвэл дутах магадлалтай. Тухайлбал, оргил гарцтай үйлдвэрлэлийн жилүүдэд жилийн орлого нь дөрвөн тэрбум доллараас давж болох бөгөөд бусад жилүүдэд илэрхий бага байж болно. Тооцоолсон дундаж нийт орлого жилд 2.3 тэрбум ам.доллар бөгөөд энэ нь ойролцоогоор 70 хувийн буюу 1.5 тэрбум ам.долларын эдийн засгийн өгөөжийг дотоодын эдийн засагт шингээнэ. Энэ үзүүлэлт Монгол Улсын 2017 оны ДНБ-ий 15 хувьтай тэнцэхүйц байгаа нь нэг компанийн хувьд онцлохуйц хувь нэмэр болно.

Юуны түрүүнд үйл ажиллагааны нийт орлогын 18 хувь нь татвар, нөөц ашигласны төлбөр хэлбэрээр, жилд дунджаар 400 сая ам.доллар болон Засгийн газарт очдог. Энэ нь Засгийн газарт их хэмжээний бэлэн мөнгөний эх үүсвэр болж байгаа бөгөөд дунджаар жил бүр 400 шинэ сургууль, эсвэл 2,000 км хатуу хучилттай зам барихад хүрэлцэнэ. Мөн анхны хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн зардлаа төлөх нь өөрөө эдийн засгийн хамгийн том үр ашигт тооцогддог. Засгийн газар болон хөрөнгө оруулагчдад хуваарилагдах ногдол ашиг ч бас үүнд хамаарна. Нийт орлогын 16 хувь нь хуримтлал болон үлдэх бөгөөд үүнийг төслийн үнэ цэнийг хадгалах болон уурхайн төлөвлөсөн өргөтгөлүүдэд хөрөнгө оруулахад зарцуулдаг. Эцэст нь хэлэхэд, ажиллах хүчний зардал нь эдийн засгийн өгөөжийн хамгийн бага хувийг эзэлдэг ч дотоодоос хангах ажлын байрыг хадгалж үлдэх төдийгүй, нэмж бий болгож байгаа нь мөнгөөр хэмжигдэхгүй үнэ цэнэ билээ. Хөдөлмөрийн хөлс нь жилд дунджаар 125 сая ам.доллар буюу нийт орлогын зургаа орчим хувийг эзэлдэг бөгөөд энэ нь дотоодын худалдан авалт буюу мөнгөний эргэлтийг мэдэгдэхүйц эрчимжүүлдэг.


Бэлтгэн нийлүүлэгчид төлөх төлбөр нь нэмүү үнэ цэнийн тооцоонд ордоггүй боловч эдийн засгийн томоохон өдөөгч/хөдөлгөгч болох бөгөөд учир нь ажил эрхлэлт буюу бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг дэмждэг. Нийт орлогын гуравны нэг буюу жилд дунджаар 700 сая ам.долларыг ханган нийлүүлэгчдээс бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулдаг.

“ОЮУ ТОЛГОЙ” ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ Улс орны хэмжээнд үнэ цэнийг бий болгох нь

Нэмүү үнэ цэнэ гэдэгт татвар, нөөц ашигласны төлбөр (роялти) ороод зогсохгүй цалин хөлс, ханган нийлүүлэгчид төлөх төлбөр, ханган нийлүүлэгчид үйл ажиллагаанаасаа хүртэх ашиг багтана. Төслийн нийт үргэлжлэх хугацаанд Засгийн газар “Оюу толгой” компанийн бий болгох бэлэн мөнгөний урсгалын тал илүү хувийг хүртэх боломжтой.



ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ТӨЛӨХ ТӨЛБӨР



“Оюу толгой” компани нь Монголын уул уурхайн ханган нийлүүлэлтийн салбарыг хөгжүүлэгч

“Оюу толгой” компани нийт худалдан авалтынхаа гуравны хоёроос илүү хувийг Монголын компаниудаас худалдан авдаг. Энэ нь нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхийн зэрэгцээ дотоодын эдийн засгийг чадавхижуулдаг. “Оюу толгой” компанийнх нь үлэмж их ашигт малтмалтай Чили зэрэг орнуудын худалдан авалтын хувь хэмжээтэй эн тэнцүү байна.

“Оюу толгой” ХХК-д өндөр үр чадвартай монгол залуус ажилладаг. Одоогийн байдлаар “Оюу толгой” компани нь 2,500 гаруй үндсэн ажиллагсадтай. Энэ тоо нэгдүгээр үе шатны барилга, бүтээн байгуулалтын явцад 18,000 хүрсэн. Аль ч тохиолдолд ажил эрхлэлттэй холбоотой эдийн засагт үзүүлж буй үржүүлэгч нөлөө үлэмж их юм.


Монголчууд нийт ажиллагсдын 95-аас дээш хувийг бүрдүүлдэг



ХҮНИЙ
НӨӨЦИЙН
ЗАРДАЛ



Өнөөдрийг хүртэл
2 тэрбум
ам.долларыг
дотоодын 600 гаруй
ханган нийлүүлэгчид
зарцуулав




БИЗНЕСТ ДАХИН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ХИЙСЭН

Монголын эдийн засаг дахь “Оюу толгой” компанийн үржүүлэгч нөлөө

Улсын ДНБ болон ажил эрхлэлтэд оруулж буй хувь нэмэр нь “Оюу толгой” компанийн эдийн засагт үзүүлж буй үржүүлэгч нөлөө юм. Монголын ханган нийлүүлэлтийн сүлжээ бүрэн хэмжээгээр ажилласнаар Засгийн газар, ханган нийлүүлэгчид, ажиллагсдын хэрэглээ идэвхэжнэ. Ингэснээр ДНБ-д үзүүлэх нөлөө хоёр дахин, одоо байгаа ажлын байр дөрөв дахин нэмэгдэнэ гэж тооцов.



ТАТВАР, НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР



1.96 тэрбум

ам.долларын татвар, нөөц ашигласны төлбөрийг Засгийн газарт аль хэдийн төлөөд байна. (2017 оны 12 сарын 31-ний байдлаар дотоодын ханган нийлүүлэгчдэд төлсөн НӨАТ багтсан дүн)



“Оюу толгой” компани нь Засгийн газарт орлогын хэд хэдэн өөр урсгал бий болгодог.


“Оюу толгой” компани нь уурхайнхаа ашиглалтын хугацаанд татвар, ногдол, ашигт малтмал ашигласны төлбөрт нийтдээ 35 тэрбум гаруй ам.доллар төлнө гэж таамаглаж байна. 2030 онд хувьцаа эзэмшигчийн зээл бүрэн төлөгдсөний дараа жилийн татварын орлого эрс өснө.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛБӨР

“Оюу толгой” бол маш их хөрөнгө шаардсан төсөл

Их хэмжээний хөрөнгө оруулалтын анхны зардлаа хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахаас өмнө төлөх ёстой байдаг. Хувьцаа эзэмшигчид анхны ашгаа хүртэж эхлэх үед Засгийн газар хэдийнээ татвар, нөөц ашигласны төлбөр хэлбэрээр хамгийн багадаа 6 тэрбум ам.доллар авсан байх болно.



11.8 тэрбум ам.доллар

Олон улсын хөрөнгө оруулагчид болон банкны зээлийн санхүүжилт

Эх сурвалж: Ерго Стратеги Групп, “Оюу толгой” компанийн мэдээлэлд үндэслэв

Зураг 16. 2018-2103 оны жилийн дундаж орлогын задаргаа



Эх сурвалж: “Оюу толгой” компани

Татаж авах

Засгийн газарт төлөх татвар, нөөц ашигласны төлбөр, бусад өгөөж


Улс орнуудын татварын тогтолцоо ялгаатай байдаг. Улсад төлөх татвар, бусад төлбөрийн хэмжээг тухайн улсын татварын хуулиар зохицуулдаг. Харин “Оюу толгой” мэтийн том хэмжээний нүсэр төслүүдийн хувьд татвар, төлбөрийн нөхцөлийг уул уурхайн тусгай гэрээгээр зохицуулах нь бий. Татвар нь Засгийн газрын орлогын зөвхөн нэг хэсэг юм. Түүнээс гадна Засгийн газар нь ашигт малтмалын өмчлөгч болон мөн эдийн засгийн ерөнхий зохицуулагчийн хувиар давхар өгөөж хүртдэг. “Оюу толгой” төслийн тухайд Монголын Засгийн газар хөрөнгө оруулагчийн хувиар мөн оролцдог билээ. Эдгээр ялгаатай үүрэг оролцоо бүр нь өөр өөрийн гэсэн өгөөжийн урсгалыг бий болгодог.

“Дэлхийн уул уурхайн олонх төслийн хувьд татварыг тогтворжуулах нь хөнгөлөлтөд тооцогддоггүй. Учир нь, энэ хөнгөлөлт Засгийн газрын орлогыг бууруулдаггүй. Харин тогтворжуулалтгүй нөхцөлд ирээдүйд татвар өөрчлөгдөх магадлалтай бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтад нөлөөлөхүйц томоохон эрсдэл юм. Хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулж, татварыг тогтворжуулснаар тухайн улс орны бусад хөрөнгө оруулагчийг татах таатай орчныг бүрдүүлдэг”.

Татвар

Монгол Улсын Засгийн газар нь эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан татварын түвшнийг тогтоох замаар эдийн засгаа удирддаг. “Оюу толгой” компани нь импортын албан татвар болон НӨАТ-ыг заавал төлөх үүрэгтэй. Энэ нь хэрэглээн дээр тогтоож буй татвар бөгөөд төслийн бүтээн байгуулалт гэх мэт том хэмжээний хөрөнгө оруулалт хийж байх үед Монгол Улсад нэн чухал татвар юм. Харин компанийн орлогын татвар нь үйл ажиллагаа нь жигдэрч, хөрөнгө оруулагчид ашигтай ажиллаж эхэлсний дараа тооцогддог учраас Засгийн газрын орлогын голлох эх үүсвэр болж хувирдаг. Түүнчлэн бусад нэмэлт хураамж, шимтгэлүүдийг ч мөн “Оюу толгой” компани давхар төлөх үүрэгтэй.

Зураг 17. Өнөөг хүртэл Засгийн газарт төлсөн төлбөр, он, төрлөөр, ам.доллараар



Татаж авах

Эх сурвалж: "Рио тинто" компани

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь дахин сэргэхгүй баялгийг олборлосны төлөө баялгийн эзэн болох Монголын ард түмэнд нөхөн төлбөр болгон өгөх зориулалттай. Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль энэ төлбөрийг зэсийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон эрдсийн дүнгийн таван хувьтай тэнцэхүйц хэмжээгээр төлөхөөр заажээ. Иймд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь компанийн ашгаас үл хамаарах учир дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүний үнэ унасан ч Засгийн газар зохих хэмжээний төлбөр авсаар байх баталгааг хангаж байдаг.

Ногдол ашиг


Засгийн газар "Оюу толгой" төслөөс хувь эзэмших шийдвэр гаргасан билээ. Энэхүү шийдвэрээр хөрөнгө оруулагчийн хувьд төслөөс олох ашиг, эрсдэлийг хуваалцах үүргийг хүлээсэн болно. Засгийн газар нь хөрөнгө оруулалтын зээлээ хүүгийн хамтаар төлж дууссаны дараа өөрийн 34 хувьд ногдох ашгаа авч эхэлнэ. Ингэснээр бусад хөрөнгө оруулагчийн адил хүртэх ногдол ашгийн хэмжээ нь төсөл ашигтай ажиллах эсэхээс шууд хамаарна.

Төлөвлөсөн болон төлсөн төлбөр

Засгийн газарт очих өгөөж уг төслийн нийт хугацаанд төрөл бүрийн хэлбэрээр төлөгдөнө. Өдгөө "Оюу толгой" компани нь аль хэдийн томоохон татвар төлөгч болсон бөгөөд бүх төрлийн татвар, нөөц ашигласны төлбөрт хоёр тэрбум шахам ам.доллар (дотоодын ханган нийлүүлэгчдэд төлсөн НӨАТ багтсан дүн) төлөөд байна. Бусад хувьцаа эзэмшигчид 2030 оноос л эхний ашгаа хүртэж эхлэх бөгөөд тэр үед Засгийн газар олон тэрбум долларыг татвар, нөөц ашигласны төлбөр хэлбэрээр аль хэдийнэ авчихсан байна гэсэн үг.

Одоогийн авч буй төлбөр, хураамж болон ирээдүйн ногдол ашгаар орж ирэх мөнгөн урсгалаас Засгийн газар урьдчилж санхүүгийн үр ашиг хэрхэн хүртэж буй болон төсөлд оролцогч талуудын хүртэх өгөөж хэр шударга хуваарилагддаг болохыг харж болно. Компани НӨАТ, импортын татварыг байнга төлөх бөгөөд ялангуяа бүтээн байгуулалтын үе шатанд хамгийн өндөр байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь үүнээс урвуу, бүтээн байгуулалтын үе шатанд бага ч ашигт малтмалын гарц оргилдоо хүрэхэд төдий хэмжээгээр өснө. Мөн хөрөнгө оруулагчид ашгаа олж эхлэх үед орлогын албан татвар хэлбэрээр Засгийн газрын орлого нэмэгдэх бөгөөд бүтээн байгуулалтын оргил үед жилийн орлогын албан татвар дунджаар 500 сая ам.доллар байхаар тооцооллоо. Засгийн газрын ногдол ашгийн төлбөрийг анхны хөрөнгө оруулалт болон зээлийн хүүг төлж дуусмагц олгож эхэлнэ.

Зураг 18. Засгийн газарт төлөх төлбөр (он, төрлөөр, ам.доллараар)



Эх сурвалж: "Рио тинто" компани

Татаж авах

Ажил эрхлэлт

Монголчуудыг ажлын байраар хангах зорилтоо хэрэгжүүлэх, давуулан биелүүлэх

“Оюу толгой” компанийн цалингийн зардал нь олон мянган ажлын байрыг тэтгэдэг юм. Том хэмжээний уурхайн төслүүдийн адилаар “Оюу толгой” компани хоёр төрлөөр ажил хөдөлмөр эрхлүүлдэг. Харьцангуй богино хугацаанд үргэлжлэх барилгын ажлын үе шатанд олон тооны, бага ур чадвартай ажиллах хүчийг ажиллуулах шаардлагатай байдаг. Харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсний дараа уурхайд цөөн тооны байнгын ажлын байранд өндөр ур чадвартай ажилчдыг ажиллуулах шаардлагатай болно. Олонх уурхай бүтээн байгуулалтын ганц үндсэн үе шаттай байдаг бол “Оюу толгой” төслийн бүтээн байгуулалтын хэд хэдэн үе шатны явцад түр ажлын байрнаас өргөтгөл, шинэ бүтээн байгуулалтын ажил явагдахад эдгээрт шилжин ажиллах боломжийг ажилчдад олгодог.


“Оюу толгой” компани орон нутгийн иргэдийг ажлын байраар хангахыг нэн тэргүүнд зорьдог. Мөн Монгол Улсад шинэ тутам үүсч буй болж байгаа олон тооны нарийн мэргэжлийг монгол ажилчдадаа заан сургах, чадваржуулах талаар ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Компани нь Монгол Улсын иргэдийг ажил эрхлүүлэх шаардлагыг хангаад зогсохгүй үргэлж давуулан биелүүлж байна. Барилгын бүтээн байгуулалтын явцад тус компани гадаадын мэргэжилтнүүдэд тулгуурлаж байсан ч монголчууд нийт ажиллагсдын 90 хувийг бүрдүүлж байлаа. Ил уурхайн үйл ажиллагаагаа эхэлсэн 2013 оноос хойш “Оюу толгой” нь гадаадын богино хугацааны ажилчдаа монгол мэргэжилтнүүдээр сэлгэсээр ирлээ. Үүний үр дүнд нийт ажилчдын тоонд эзлэх монгол ажилчдын тоо 2015 онд дээд цэгтээ буюу 95 хувьд хүрсэн юм. Гэхдээ үүнээс хойш энэ харьцаа бага зэрэг буурсан нь Гүний уурхайн бүтээн байгуулалтад энэ чиглэлээр мэргэшсэн гадаадын өндөр мэргэжлийн туршлагатай мэргэжилтнүүд чухал шаардлагатай болсонтой холбоотой юм. Үндсэн ажилтнуудын нэгэн адил гэрээт компаниудын орон нутгаас авсан ажиллагсдын тоо ч мөн адил амлалтаас давсан биелэлттэй байна. Харин үндсэн ажиллагсдад эзлэх орон нутгийн иргэдийн харьцаа бага байгаа нь нарийн мэргэжил шаарддаг, орон нутагт сургаж, дадлагажуулахад хугацаа их шаарддагтай холбоотой.

“Оюу толгой” компани монгол ажилчдыг ажлын байран дээрээ өсөн дэвшиж, удирдах албан тушаал хаших боломжийг байнга олгодог. Одоогоор удирдах албан тушаалын орон тооны дөрөвний гурвыг монгол ажиллагсад эзэлж байна. Тэдний эзэмшсэн ур чадвар өнөөдрийн олон улсын зах зээл дээр хөрвөх чадвартайг баталж, 32 монгол хүн “Рио тинто” группийн хилийн чанад дахь ахлах, удирдах албан тушаалыг хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй хашиж байна. Үүнд “Рио Тинто” группийн Эрчим хүч, Эрдэс баялгийн группийн ерөнхий захирал гэх мэт албан тушаалуудыг дурдаж болно.

“Оюу толгой” компанийн сургалтын хөтөлбөрүүдийн хүрээ өөрийн ажилчдаас хэдийнэ хальжээ. Компани улс даяар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн зургаан төвийг шинээр байгуулах буюу өмнө байсныг нь засч сайжруулсан бөгөөд тэнд Монголын ирээдүйн уул уурхай, техникийн мэргэжилтнүүдийг бэлтгэж байна”.

Зураг 19. “Оюу толгой” компанийн дотоодоос авсан ажилчдын тоо нь төлөвлөснөөс давсан



Татаж авах

Эх сурвалж: “Оюу толгой” ХХК

Боловсрол, сургалтын систем дэх хөрөнгө оруулалт

“Оюу толгой” компани уул уурхайн нөлөөллийн бүсийн нутгийн удирдлагатай өргөн хүрээнд хамтран ажиллаж боловсрол, сургалтын олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээр санаачилга, хөтөлбөр нь Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан бөгөөд 2010 онд Боловсролын яамтай байгуулсан Хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт илүү дэлгэрэнгүй тусгагдсан юм. Одоогоор эдгээр боловсрол, сургалтын хөтөлбөрүүдэд 168 тэрбум төгрөг зарцуулаад байна. Уг хөтөлбөр нь “Оюу толгой” компанийн өөрийн хэрэгцээнээс хэдийнэ хальж улс орны хэмжээнд барилгын коллеж, уул уурхайн сургууль зэрэг техникийн боловсролын салбарт шинэчлэл, хөрөнгө оруулалт болон хэрэгжиж буй. Энэ хөрөнгө оруулалтын үнэ цэнийг техник мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн зургаан төвийг шинэчилсэн явдлаар үнэлж болно.

Тус хөтөлбөрийн хүрээнд орон даяар түгсэн мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг чадавхижуулах хөтөлбөрийг санхүүжүүлээд байна. 2011-2015 онд мэргэжлийн сургалтын төвийн 60 менежер, 210 багшийг сургалтад хамруулав. Эдгээр багш-суралцагчдаар дамжуулан бусад багш нарыг сургах зорилготой. Үүний үр дүнд улс даяар 47 сургуулийн 1,800 багш сургалтад хамрагджээ.

Сургалтын тэтгэлэг бол Монголын шилдэг оюутнууд өөрийгөө үнэлүүлж, оюуны нөөц, чадавхиа дээд хэмжээнд ашиглах боломжийг олж авдаг хэрэгсэл юм. “Оюу толгой” компани тэтгэлэгт хөтөлбөрүүдийг дэмжиж санхүүжүүлснээр Монгол Улсын уул уурхайн салбарын ирээдүйн манлайлагчид, мэргэжилтнүүдийг бэлтгэх, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаа юм.

Дотоодын худалдан авалт

Дотоодын худалдан авалтаар дамжуулан үр өгөөж хүртээх нь

Дотоодын худалдан авалт нь уул уурхайн баялгийн өгөөжийг эзэн орны эдийн засагт оруулах арга зам юм. Ингэснээр Монгол Улсад ажлын байр, орлого нэмэгдүүлэх нь дамжиггүй. Мөн дотоодын худалдан авалт нь зардал, хугацааг хэмнэдэг. Нөгөө талаас, дотоодын бизнес эрхлэгчидтэй харилцан ашигтай хамтран ажиллах нь “Оюу толгой” компанийн хувьд нэр төрийн хэрэг юм.

Уурхайн үндсэн үйл ажиллагааны үед шаардагдах бараа, үйлчилгээний нэр төрөл нь барилга бүтээн байгуулалтын үеийнхээс цөөн байдаг. “Оюу толгой” компанид урт хугацааны үйлдвэрлэлийн үед байнга хэрэглэх бараа, бүтээгдэхүүн шаардлагатай байдаг учир дотоодын ханган нийлүүлэгчдэд ирээдүйг харж, өргөжин тэлэх боломж илүү гардаг. Дотоодын ханган нийлүүлэгчид нь эхэндээ хямд үнэтэй, хялбар бараа үйлчилгээ нийлүүлдэг бол цаг хугацаа өнгөрөх тусам нарийн төвөгтэй, ахисан түвшний үнэ өртөг ихтэй бараа үйлчилгээгээр хангах чадвартай болно.

Маш том газар нутагтай, далайд гарцгүй, цөөн хүн амтай Монгол Улсын дотоодын аж үйлдвэрийн салбар нь олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар харьцангуй сул байдаг. Түүнчлэн өмнөд талаараа дэлхийн хамгийн их өрсөлдөх чадвартай, том ханган нийлүүлэгч болох БНХАУ-тай хиллэдэг, Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь дэлхийн хэмжээний уул уурхайн компаниудын стандарт, шаардлагыг хараахан хангаж чадахгүй байгаа гэх мэт сорилтууд оршсоор байна.

Ханган нийлүүлэгчдийг чадавхижуулах хөтөлбөр

“Оюу толгой” ХХК нь дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжих, бараа үйлчилгээг нь худалдан авах зорилтоо биелүүлэхийн тулд ханган нийлүүлэгчдийг чадавхижуулах хөтөлбөрийг өөрийн санаачилгаар боловсруулан ажиллаж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд баримтлах бодлого, компанийн стандарт, боломжит ханган нийлүүлэгчидтэй хамтын ажиллагаагаа ил тод болгох чиглэлээр хамтран ажиллаж, тэднийг эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, чанар, байгаль орчны нөлөөллийн стандартуудыг мөрдөн ажиллахад нь туслалцаа үзүүлдэг. Монголын Засгийн газар, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Хамтын ажиллагааны хороогоор дамжуулан уг хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллаж байна.


“Оюу толгой” компани ханган нийлүүлэгчдийн чадамжийг хөгжүүлэх үүднээс гадаадын хэд хэдэн байгууллагатай хамтран ажиллахаар түншлэлийн харилцаа тогтоогоод байна. Түншлэлийн зорилго нь ханган нийлүүлэгчдийн техникийн ур чадварыг хөгжүүлэх, бизнесийн ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх явдал юм. Түүнчлэн өсөн дэвших боломжтой ханган нийлүүлэгчдийг санхүүжилтийн эх үүсвэртэй холбон бизнесээ өргөтгөх боломж олгодог.

“Оюу толгой” төслийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа нь Монгол Улсад уул уурхайн ханган нийлүүлэлтийн цоо шинэ салбар үүсэх эхлэлийг тавьсан бөгөөд төсөл дууссан ч эдгээр ханган нийлүүлэгчид бусад уурхайг даган ажлын байр бий болгон орлого олох боломжтой. “Оюу толгой” компанийн худалдан авалт хариуцсан хамт олон үйл ажиллагааны зардлыг оновчлох замаар Монгол Улсад илүү өгөөж хүртээхийг эрмэлздэг”.


Дотоодын худалдан авалтаараа тэргүүлэгч

“Оюу толгой” ХХК нь гадаад худалдан авалтыг дотоодын худалдан авалтаар солих, нэмүү өртөг бүхий эх орны бүтээгдэхүүнийг дэмжих, шинэ ур чадварыг нутагшуулах чиглэлээр амжилттай ажиллаж байна. Жишээ нь, импортоор авдаг байсан зэсийн баяжмал хийх уутыг Даланзадгадад үйлдвэрлэж, Тайландаас импортолж байсан ган бөмбөлгийг дотоодоосоо худалдан авдаг болов. Энэ бүхэн “Оюу толгой” компани богино хугацаанд дотоодын худалдан авалтыг дэмжин ажиллаж, дэлхийн хэмжээний бусад уурхайтай харьцуулахад сайн жишиг тогтоосныг харуулна. “Оюу толгой” ХХК 2017 онд үндэсний 669 компаниас нийт 336 сая долларын өртөгтэй худалдан авалт хийсэн нь тухайн жилийн үйл ажиллагааны нийт зардлын 69 хувьтай тэнцэж байна. Цаг хугацааны явцад үндэсний ханган нийлүүлэлтийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр Өмнөговь аймгийн ханган нийлүүлэгчдийн ур чадвар гайхалтай сайжирч байна. Иймээс тус компани нь эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, чанар, байгаль орчин, техникийн стандартуудыг хангасан, үнийн хувьд өрсөлдөх чадвартай л бол орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг илүүтэйгээр сонгодог болсон гэсэн үг. Үүний дүнд 2010 оноос хойш Өмнөговь аймагт бүртгэлтэй компаниудаас хийсэн худалдан авалт 200 дахин нэмэгджээ.


Зураг 20. Дотоодын худалдан авалтын хэмжээг гадаадын уул уурхайн компаниудынхтай харьцуулах нь




Зураг 21. "Оюу толгой" компани 2010–2017 онд үндэсний ханган нийлүүлэлтэд 2.25 тэрбум ам.доллар зарцуулсан



Зураг 22: Аажим эхэлсэн боловч одоогоор жилд 100 сая орчим ам.долларыг Өмнөговийн ханган нийлүүлэгчдэд зарцуулж байна.



Зураг 23. “Оюу толгой” компани нь 2010 оноос хойш орон нутгийн төсөл, хөтөлбөрийг дэмжин 50 сая долларын хөрөнгө оруулсан



Эх сурвалж: “Оюу толгой” ХХК

Татаж авах

Нийгмийн хөрөнгө оруулалт

Орон нутгийн тогтвортой хөгжил

Нэмүү өртгийн тооцоонд ордоггүй ч компани нь орон нутгийн тогтвортой хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг юм. Хайгуулын үеэс эхлэн “Оюу толгой” ХХК, түүний хөрөнгө оруулагчид тухайн аймаг, сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн төсөл санаачилгуудыг дэмжиж ирсэн билээ.

50 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалтыг орон нутгийн нийгэм-эдийн засгийн дэд бүтэц, эрчим хүч, сургууль, эрүүл мэндийн байгууламж, зам барьж байгуулах, усан хангамж, хог хаягдлын менежментийн төслүүдэд зарцуулаад байна. Үүний зэрэгцээ нийгмийн тэргүүлэх чиглэлүүдээр тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж, багш, эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадваржуулахад зориулж байна.

Үүний зэрэгцээ уул уурхайн салбарын түүхээс харвал уурхайн ажилчид нь компаниас зааж өгсөн газарт амьдрах хэрэгтэй гэдэг ойлголтыг баримталж, зэргэлдээх суурин газруудад их хэмжээний тогтвортой бус хөрөнгө оруулалтуудыг хийсэн жишээ олон бий. Өнгөрсөнд Монголын уул уурхайн компаниуд нь гаднын мэргэжилтнүүдийн ая тухыг хангах, мөн татварын ихээхэн хөнгөлөлт, дэмжлэгийн хариу болгож хот суурингуудад хөрөнгө оруулалт хийж байжээ. Харин “Оюу толгой” компанийн бодлого нь ажилчдынхаа хаана амьдран суурьших сонголтыг хүндэтгэн үзэхэд чиглэдэг.

Компани нь дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлж байгаа. Ингэхдээ орон нутгийн иргэдийн дэд бүтэц, орон сууц, эдгээртэй холбогдох үйлчилгээний бодит эрэлт хэрэгцээнд үндэслэдэг. Уул уурхайн компани үндэсний болон орон нутгийн хэмжээнд Засгийн газартай нягт хамтран ажиллах замаар орон нутгийн хэрэгцээг тогтвортой хангах хувийн хэвшлийн оролцоог бий болгох нь олон улсад шилдэг практик болохыг хүлээн зөвшөөрдөг.

Түншлэл, ил тод байдал

Төсөл бүтээн байгуулалтын шат руу шилжих явцад орон нутагт хийх хөрөнгө оруулалт нь стратегийн хувьд улам бүр чухал болов. “Оюу толгой” 2011 оноос эхлэн орон нутгийн болон бүс нутгийн түншлэлийн харилцааг бэхжүүлж, хөгжлийн сангийн суурийг аажмаар тавьж эхэлсэн юм. Дөрвөн жил үргэлжилсэн хэлэлцээрийн эцэст 2015 онд Өмнөговь аймаг, Даланзадгад хот, Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдтай Хамтран ажиллах гэрээг үзэглэсэн билээ. Энэ нь “Оюу толгой” компани, түүний түншүүд хамтран нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих Монголын анхны Хамтын ажиллагааны гэрээ юм.

Уг гэрээ нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” (ГОХДС)-гийн суурь болж, Өмнөговь аймгийн тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс жил бүр таван сая долларын санхүүжилт хийдэг болсон.

ГОХДС 2015 оноос 2018 оны эхэн үеийн байдлаар орон нутгийн тогтвортой хөгжилд чиглэсэн 15 сая

ам.долларын үнэ цэн бүхий нийт 78 төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллажээ. ГОХДС-гийн онцлог давуу тал нь төслийн сонгон шалгаруулах үйл явцын ил тод, нээлттэй байдал юм. Оролцогч талууд орон нутгийн иргэд, засаг захиргаа хамтран ГОХДС-гийн хөрөнгийг хэрхэн зарцуулахыг зөвшилцөж, нэгдсэн шийдвэр гаргадаг. Тухайлбал, хүүхэд асрамжийн байгууллага болон хүүхдийн цэцэрлэг хангалтгүй байгаа нь эцэг эхийн ажилдаа зарцуулах цагт нөлөөлж буйг, малын эрүүл мэнд малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлж буйг тодруулах зэргээр асуудлыг хамтдаа шийдсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

ГОХДС орон нутгийн хувийн бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд бичил санхүүгийн хөтөлбөр хэрэгжүүлдэг. Энэхүү хөтөлбөрт хамрагдах бизнесүүдийг өрсөлдөх чадамжаар нь үнэлдэг бөгөөд тэд заавал “Оюу толгой” компанид бараа бүтээгдэхүүн нийлүүлэх албагүй. Орон нутагт хэрэгжиж буй энэ хөтөлбөр нь орон даяар хэрэгжиж буй бизнес эрхлэгчдийг Оюу толгой компанийн ханган нийлүүлэгч болоход дэмжлэг үзүүлэх “Хас банк”-тай хамтарсан бичил санхүүгийн төсөлд нэмэлт дэмжлэг болж буй юм.

Өгөөжийн хүртээмж

Хуримтлагдсан болон жилийн мөнгөн урсгал

Өмнөх бүлгүүдэд “Оюу толгой” компанийн жил тутмын нэмүү үнэ цэнийг санхүү бүртгэлийн үүднээс авч үзсэн билээ. Төслийн эдийн засгийн нийт нөлөөг тооцох өөр нэгэн арга бол төслийн үргэлжлэх хугацаанд Засгийн газар болон хөрөнгө оруулагчдад нийлүүлсэн нийт бэлэн мөнгөний урсгалыг тодорхойлох явдал юм. Энэ нь жил бүрийн бэлэн мөнгөний урсгалыг хуримтлуулан бодитоор тооцдог арга юм.

Мөнгөн урсгалын шинжилгээ нь тухайн нэг жилд хийсэн мөнгөн урсгалын гүйлгээг авч үздэг мэт харагдавч төслийн хэд хэдэн жилийг хамруулж тооцох нь бий. Энэ тохиолдолд түүнийг хуримтлагдсан мөнгөн урсгал гэж үздэг. Хуримтлагдсан мөнгөн урсгалын шинжилгээнд төслийн ирээдүйн болоод өнгөрсөн цаг хугацааг шинжилж үздэг.

Мөнгөн урсгал нь хөрөнгө оруулалтаар санхүүжсэн мөнгө хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдийн хооронд хэрхэн буцан хуваарилагдаж байгааг харуулдаг. “Оюу толгой” төслийн хувьд энэ шинжилгээ нь Засгийн газар болон Хөрөнгө оруулагчдын хооронд төслийн нийт хугацаанд эргэлдэх бэлэн мөнгөний урсгалыг илэрхийлнэ. (Энэхүү мөнгөн урсгалын тооцоолол нь 41-р хуудасны төсөөлөл дээр үндэслэсэн болно)


Өгөөжийг хуваалцахуй

Хөрөнгө оруулагчид ашиг хүртэхийн тулд хөрөнгө оруулалт хийдэг. Тэд хөрөнгө оруулах явцдаа хөрөнгийн, техникийн, геологийн зэрэг бусад эрсдэлтэй нүүр тулдаг бөгөөд оруулсан хөрөнгө нь энэ бүх эрсдэлийг даван гарч, оруулсан хөрөнгөө бүрэн нөхөхийн сацуу тодорхой хэмжээний ашиг олохыг зорьдог. Засгийн газар нь эрдэс баялгийн эзэн бөгөөд эдийн засгийн ерөнхий зохицуулагчийн хувьд нөөц ашигласны төлбөр, татвар хэлбэрээр өгөөж хүртэж, дээр дурдсан хөрөнгө оруулагчдын эрсдэлээс чөлөөлөгддөг. Засгийн газар төсөлд хөрөнгө оруулагч болохоор шийдсэн нөхцөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр ашиг хүртэх эрхтэй.

“Туркойз хилл ресурс” компани 2010 онд уг төсөлд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхэлснийг 24-р Зурагт харуулсан мөнгөн урсгалаас харж болно. Хөрөнгө оруулагчдын анхны өндөр дүнтэй санхүүжилт төсөлд сөрөг мөнгөний урсгал бий болгодог бөгөөд Гүний уурхайн өргөтгөлийн бүтээн байгуулалт дуусах үед ирэх арван жилийн хугацаанд эерэг мөнгөний урсгал болж хувирна. Энэ бүх хугацаанд Засгийн газар авдаг татвар, нөөц ашигласны төлбөрөө тогтмол авсаар байх болно. Хувьцаа эзэмшигчдийн хувьд жил тутмын мөнгөний урсгал аажмаар уруудах хандлагатай бөгөөд төслийн нийт хугацааг дуустал үргэлжлэх нь тодорхой байна.

Ашигт малтмалын зах зээлийн үнийн хэлбэлзэл, тодорхой бус байдал нь ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж өгөөж хуваарилалтыг өөрчлөх боломжтой. Аль ч тохиолдолд Монгол Улсын Засгийн газар төслийн эдийн засгийн нийт өгөөжийн талаас илүү хувийг хүртэх нь тодорхой байгаа бөгөөд үлдэх өгөөжийг бусад хөрөнгө оруулагчид хуваалцах юм. Засгийн газар төслийн өгөөжийн ихээхэн хувийг урьдчилж бэлэн мөнгө гарган өөрөө санхүүгийн шууд хариуцлага үүрэхгүйгээр хүртэж буйг энд дурдах нь зүйтэй болов уу.

Зураг 24. “Оюу толгой” компанийн хөрөнгө оруулагчдын хуримтлагдсан мөнгөн урсгал, (сая ам.доллараар)



Татаж авах

Зураг 25: Монгол Улсын Засгийн газар болон хөрөнгө оруулагчдын хүртэх өгөөж



Эх сурвалж: “Эрго стратеги групп”

Татаж авах

Аливаа хөрөнгө оруулалтаас өгөөж хүртэхийн тулд гарч болох эрсдэлийг ч хуваалцах ёстой. “Оюу толгой” төсөл нь техникийн ч, санхүүгийн ч эрсдэлтэй хөрөнгө оруулалтад зүй ёсоор тооцогдоно. Түүнчлэн төслийн өгөөжийн таамаглал бодит байдал дээр хэрэгжихгүй байх талтайг дээр тайлбарласан. Ийм нөхцөлд хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгийн өгөөжөө хүртэх боломжгүй боллоо гэхэд бүтээн байгуулалтад урьдчилж бэлэн мөнгө гаргаагүй учир Монгол Улсын Засгийн газар энэ мэтийн эрсдэлээс бүрэн хамгаалагдаж буй хэрэг юм.

Үржүүлэгчийн нөлөө

Нэмүү үнэ цэнэ ба ажлын байрны үржүүлэгч

Эдийн засагт үзүүлэх уул уурхайн салбарын нийт нөлөө нь шууд нөлөөнөөсөө хавьгүй өргөн хүрээтэй байдаг. Үнэхээр ч “Оюу толгой” ХХК-иас төлсөн ажилчдын цалин, ханган нийлүүлэгчдэд төлсөн төлбөр, татвар зэрэг нь эргээд эдийн засгийн эргэлтэд орж, дотоодын хэрэглээг нэмэгдүүлж, мөнгөний урсгалыг эрчимжүүлэх замаар үнэ цэнэ нь хэд дахин үржигддэг. Эдийн засгийн аргуудыг ашиглан үнэ цэнэ үүсгэж буй төрөл бүрийн үржүүлэгчийн нөлөөллийг хэмжиж болдог. Үүнд:

- **Шууд бус нөлөө** нь нийлүүлэлтийн гинжин хэлхээнээс үүсч буй эрэлтээр тодорхойлогдоно. Үүнийг “ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний нөлөө” гэдэг.
- **Дам нөлөө** нь төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанаас хамаарч, ажилчдын ар гэрийн болон ханган нийлүүлэгч компанийн хэрэглээ нэмэгдэх учир эргээд эцсийн эрэлтийг нэмэгдүүлнэ. Үүнийг “хэрэглээний нөлөө” гэдэг.

Үржүүлэгч тус бүрийн хувьд анхдагч болон нийт нөлөөг тооцоолохоос гадна шууд (direct), шууд бус (indirect), түүнчлэн хэрэглээг дэмжсэн нөлөөг (induced) тооцоолох боломжтой. Шууд ба шууд бус нөлөөг тооцсоныг энгийн үржүүлэгч гэдэг бол шууд, шууд бус болон дам нөлөөг хамтад нь тооцсоныг нийт үржүүлэгч гэнэ. Тэгэхээр нийт үржүүлэгч нь төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг өргөн хүрээнд буюу шууд, шууд бус, дам нөлөөг хамтад нь тооцдог. Жишээлбэл, уул уурхайн салбарын ажлын байрны үржүүлэгч 3 байна. Энэ нь шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр уул уурхайн салбарт 100 шинэ ажлын байр бий болгосон ч нийт эдийн засагт 300 ажлын байр шинээр үүсгэсэн гэсэн үг. (шууд нөлөөгөөр уул уурхайн салбарт 100, шууд бус болон дам нөлөөнөөс 200 шинэ ажлын байр эдийн засагт үүссэн).

Үржүүлэгч нь улс бүрт ялгаатай үнэ цэнийг үүсгэдэг. Учир нь, тухайн нийгмийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, хуримтлалын соёл болон зуршлаас хамаарна. Түүнчлэн аж үйлдвэрийн салбар бүрт үржүүлэгчийн нөлөө ялгаатай үйлчлэхээс гадна дотоод ханган нийлүүлэлтийн сүлжээ, ажиллах хүчний бүтээмжээс нь хамааран өөр өөр байна. “Оюу толгой” шиг уул уурхайн олборлох болоод боловсруулах үйл ажиллагааг хослуулан явуулдаг төслийн хувьд үржүүлэгчийн нөлөө нь олборлох болон метал боловсруулах салбараас шууд хамааралтай байдаг.

“Хэрэв шууд, шууд бус, дам нөлөөллийг хэмждэг нийт үржүүлэгчийн нөлөөг тооцвол “Оюу толгой” компанийн Монголын эдийн засагт үзүүлж буй үнэ цэнийг бодитоор мэдрэх болно”.

Дэлхийн жишиг ба Монгол

“Оюу толгой” шиг хэмжээтэй том төслийн хөрөнгө оруулалтын үржүүлэгчийн эдийн засгийн нийт нөлөөг энэ тайлангаар бүрэн харуулах боломжгүй юм. Гэхдээ энэхүү тайлангаар үл үзэгдэх боловч хүчирхэг эдийн засгийн өдөөгчийн талаар тодорхой хэмжээний ойлголтыг авах боломжтой бөгөөд Монголын уул уурхайн салбарын үржүүлэгчийн мэдээллийг энэ тайланд ашиглалаа. Монголын уул уурхайн метал боловсруулах үйлдвэрийн салбарт нэмүү үнэ цэнэ үүсгэж буй үржүүлэгч нь 1.8-аас 2.1-ийн хооронд байгаа нь бусад орны ижил салбарын үржүүлэгчтэй адил байна. Тухайлбал, энэ үзүүлэлт Чили улсад 1.8, Румын улсад 3 гэх зэргээр 1.5-аас 3-ын хооронд хэлбэлздэг. Ажлын байрны үржүүлэгчийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө нь үйлдвэрлэлийн нэмүү өртгийн үржүүлэгчийн нөлөөнөөс өндөр байдаг. Энэ тайлангаар бид зэсийн уурхайн ажлын байрны үржүүлэгчийн жишгийг 4 гэж тооцож байгаа бөгөөд энэ үзүүлэлт Чилийн “Эскондида” уурхайд 3.8, Перугийн “Антамина” уурхайд 4.4 байдаг.

“Оюу толгой” ХХК-ийн үндсэн ажилчдын тоо 2,5 мянга хүрсэн нь дээр дурдсан үржүүлэгчийн нөлөөгөөр шууд бусаар 10,000 ажлын байрыг эдийн засагт шинээр бий болголоо гэсэн үг. Төслийн уурхайн барилга, бүтээн байгуулалтын үе шатанд энэ тоо улам нэмэгдэнэ. Үүнтэй нэгэн адил “Оюу толгой” төслийн нийт хугацаандаа жил бүр 1.5 тэрбум ам.долларыг Монголын ДНБ-д нэмэрлэсэн нь 2017 оны Монголын эдийн засгийн бараг 15 хувьтай тэнцэнэ. Үйлдвэрлэлийн нэмүү өртгийн үржүүлэгчийг 2 гэж тооцвол ДНБ-д оруулж буй энэ өгөөж 3 тэрбум ам.доллараар хэмжигдэнэ. “Оюу толгой” төслийн Монголын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бүрэн зураглахын тулд дээрх жишээ тоонуудыг ашиглав.





Бидний ирээдүй: Амжилтын суурь

Өмнөговь аймаг нь геологийн асар баялаг нөөцтэй. “Оюу толгой” компани уурхайгаа өргөжүүлэх, шинээр хайгуул хийх үйл ажиллагаандаа уул уурхайн байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмж татаж чадвал дэлхийд жишиг болох уул уурхайн төв болох нь маргаангүй. Ашигт малтмалын нөөц ихтэй улс бүр газар доорх баялгаа бодит үнэ цэнэ болгож чаддаггүй. Эрдэс баялгийн удирдлагыг амжилттай хийвэл уул уурхайн салбар нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгож, баялгийн жинхэнэ эзэд болсон тухайн улсын ард иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлдэг. Байгалийн баялгаар арвин атлаа хүн ам багатай, дэлхийн дэвжээнд залуу тоглогчийн хувиар Монгол Улс уул уурхайн салбар дээрээ түшиглэсэн чинээлэг улс болох цаг нэгэнт иржээ.

Оюу толгойн ирээдүй

Уурхайн бүтээн байгуулалтын үе шатууд ба өргөтгөлийн хувилбарууд

“Оюу толгой” шиг цар хүрээтэй, өвөрмөц шинж чанартай төсөл нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаардахаас гадна техникийн ярвигтай сорилтуудыг дагуулдаг. Тиймээс ийм хэмжээний төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээс өөр аргагүй болдог юм. Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь гаднаас санхүүжилт босгох хэрэгцээг хязгаарлаж, одоо ажиллаж буй уурхайгаас олсон орлогыг шинэ бүтээн байгуулалтад зарцуулах боломжийг бий болгодог. Мөн байнгын хувьсан өөрчлөгдөх зах зээлийн нөхцөлд уян хатан байдлаар ажиллах, тэр дундаа үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлэх, эсхүл бууруулах боломжтой. Бизнесээ явуулж буй хугацаандаа ашигтай ажиллах, ирэх хэдэн арван жилд уул уурхайн үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжтой. Уурхайн өргөтгөлийн суурь жишээнд одоо явагдаж буй Хойд Хюгогийн ашиглалтын 1-р давхаргын бүтээн байгуулалтын суурь бөгөөд ойр орчмын орд руу гүний уурхайгаа өргөтгөх эсэх талаар гаргах шийдвэр багтана.

Зураг 26: “Оюу толгой” компанийн ирээдүйн бүтээн байгуулалтын хувилбарууд



Эх сурвалж: “Туркойз хилл ресурс” компани

Татаж авах

“Оюу толгой” шинэ, залуу уурхайн хэдий ч эдийн засгийн өгөөжөө аль хэдийнэ Монголд өгөөд эхэлсэн. Тухайлбал, мянга мянган залуусыг ажлын байраар хангаж, дотоодын хэдэн зуун аж ахуйн нэгжийг гэрээгээр ажиллуулж, жил бүр олон зуун сая ам.долларын татвар, хураамж төлж байна. Энэ бол их юмны сэжүүр бөгөөд Монгол Улсын эдийн засагт оруулах хувь нэмэр улам бүр өсөн нэмэгдэх боломжтой”.

Ирээдүйн өсөлтийн урьдчилсан нөхцөлүүд

Эрдэс баялгийн арвин нөөцтэй улс орон бүр уул уурхайн эцсийн бүтээгдэхүүнийг эх орондоо үйлдвэрлэхийг эрмэлздэг. Гэвч энэ эрмэлзэл нь эдийн засгийн хувьд үргэлж эерэг утгыг заадаггүй. Учир нь, эрдэс баялгийг олборлож, боловсруулах нь их ялгаатай үйл ажиллагаа бөгөөд тус бүртээ өөрийн харьцангуй давуу талтай. “Оюу толгой” компани Монголд зэс хайлуулах үйлдвэр байгуулбал эдийн засгийн хэр үр ашигтай байх талаар бие даасан судалгааг 2016 онд мэргэжлийн шинжээчдээр хийлгэсэн билээ. Судалгаагаар Монголд зэс хайлуулж эцсийн бүтээгдэхүүн хийх нь эдийн засгийн хувьд ашиггүй гэсэн дүгнэлт гарсан юм. Өөрөөр хэлбэл, “Оюу толгой” компанийн хувьд зэс хайлуулах үйлдвэр барих, түүнийг ажиллуулах нь бизнесийн хувьд цэвэр алдагдал болно. Гэхдээ хөрөнгийн ашигт ажиллагааг дээшлүүлэх, технологио сайжруулах, тээвэр, эрчим хүчний дэд бүтцээ цогцоор нь шийдэх, дэлхийн зах зээл дээр зэсийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх нөхцөлүүд хангагдсан тохиолдолд ирээдүйд зэс хайлуулах үйлдвэр ашигтай ажиллах боломжтой.

“Оюу толгой”-н хэмжээ, үзүүлэлтээрээ өмнийн говьд байрлах дэлхийн уул уурхайн жишиг төв болох бүрэн боломжтой. Учир нь, дундын дэд бүтэц ашиглан зэргэлдээх ордуудыг нэгэн зэрэг хөгжүүлэх нь орд бүрийг тус тусад нь ашиглахаас хавьгүй үр ашигтай”.

Одоогийн лицензийн талбайгаас цаашилбал

Оюу толгойн уурхай нь маш өндөр эрдэсжсэн бүс нутгийн голд байрладаг. Өмнөговь аймагт байрлах дэлхийн жишиг зэсийн үйлдвэрлэл нь ирээдүйн Монголын эдийн засгийн гол тулгуур болно. Ойр байрших хайгуулын лицензийн талбайнуудад сонирхолтой нөөц хэдийнэ тогтоогдоод байна. Үүнд Оюу толгойн ордыг тойрсон “Энтри гоулд” компанийн эзэмшилд байдаг Шивээ толгой, Жавхлантын ордыг дурдаж болно. “Оюу толгой” компани нь “Энтри гоулд” компанитай эдгээр лицензийг хамтран ашиглахаар гэрээ байгуулсан. Хайгуулын ажлын үр дүнгээс хамааран тус бүс нутаг нь ойрхон орших энэ хоёр ордоос зэс үйлдвэрлэлийн бас нэг том уурхайг эх барьж авах магадлалтай байна.

Монголын хөгжлийн орон зай

Бүс нутгийн өсөлтийн хурдасгуур: Говийн бүсийн уул уурхайн кластер

Уул уурхайн кластер гэдэг нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц, ханган нийлүүлэгчдийн төрөлжсөн экосистем хөгжсөн, өндөр мэргэжлийн чадварлаг ажилтнууд цугларсан, дэд бүтэц болон технологийн цөм болсон, хамтран ажилладаг уурхай бүрт үнэ цэнийг бий болгодог тусгайлан хөгжүүлсэн бүс нутаг юм. Ихэвчлэн кластерууд органикаар үүсч эхэлдэг боловч макро эдийн засгийн тогтвортой байдал, бүс нутгийн хөгжлийн зорилт, дэд бүтцийн нэгдсэн бүтээн байгуулалт, үйлчилгээ болон ур чадварыг системтэй хөгжүүлэх, оролцогч талуудын идэвх санаачилга зэрэг бодлогын дэмжлэгээр кластер хөгжлийн дараагийн шат руу шилждэг.

Оюу толгойн орд нь нөөцийн хэмжээ, үзүүлэлтээрээ өмнийн говьд байрлах дэлхийн жишиг уурхайн төв болох бүрэн боломжтой. Учир нь, дундын дэд бүтэц ашиглан зэргэлдээх ордуудыг нэгэн зэрэг хөгжүүлэх нь орд бүрийг тус тусад нь ашиглахаас хамаагүй үр ашигтай юм. “Оюу толгой” компани дараах ажлуудыг хэдийнэ эхлүүлээд байна:

- > **Өмнийн говийн зам тээврийн систем.** Уурхайг БНХАУ-ын хил болон Ханбогд сумтай холбох авто-зам.
- > **Өмнийн говийн нисэх онгоцны буудал.** Иж бүрэн ажиллагаатай онгоцны буудлыг ашиглалтад оруулсан бөгөөд Улаанбаатар хот руу нэг цагийн дотор зорчдог.
- > **Цахилгаан эрчим хүч.** Эрчим хүч дамжуулах шугам, сүлжээ, Ханбогд сумыг төвийн эрчим хүчний системтэй холбосон.
- > **Цахилгаан станц.** БНХАУ-аас импортоор авдаг цахилгааны хэрэглээг дотооддоо цахилгаан станц барин хангах хувилбаруудыг авч үзэж байна.
- > **Орон нутгийн хэрэгцээ.** “Оюу толгой” төслийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдсэн.
- > **Орон нутагт хийх зорилтот хөрөнгө оруулалт.** “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан орон нутгийн хөтөлбөрүүдэд багагүй хөрөнгө оруулж байна.
- > **Дэд бүтэц.** Усан хангамжийг төвлөрсөн систем ус зайлуулах хоолойн хамт, зам, олон нийтэд үйлчлэх иргэдийн хөгжлийн төв, цэцэрлэгт хүрээлэн байгуулах зэрэгт хөрөнгө оруулсан.

Байгалийн баялгийн ерөөл ба хараал

Монгол Улс чанарын өндөр зэрэглэл бүхий байгалийн арвин баялагтай улс. Эрдэс баялаг нь бусад хөрөнгөтэй адил улс үндэстний үнэ цэнийн нэг хэсэг юм. Энэ утгаараа байгалийн баялаг нь улс орны эдийн засгийн хөгжлийн голлох хөдөлгүүр болдог. Уул уурхай нь газар доорх байгалийн баялгийг ил гаргаж бизнес, боловсрол, дэд бүтэц бусад хэлбэрийн хөрөнгө болгодог үйл явц. Гэхдээ, байгалийн арвин баялагтай улс болгон баялгаа зохистой ашиглаж улс орноо хөгжүүлэх нь бүү хэл доройтуулдаг гэдгийг цөөнгүй судлаачид 30 жилийн өмнө тэмдэглэсэн байдаг. Үүнийг уул уурхайн салбарт ‘Баялгийн хараал’ гэж нэрийддэг.


“Байгалийн баялгийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх хувь нэмэр нь зөвхөн тухайн улсын байгалийн баялгийн хэмжээнээс биш, төрөөс баримтлах бодлогоос мөн хамаардаг.

Энэ талын судалгаа хөгжиж, нийгмийн зөвшилцлийн шинэ бодлого болон гарч ирж байна. Цөөнгүй улс байгалийн баялгаа удирдаж чадалгүй буруу замар явж байхад зарим улс (Австрали, Ботсвана, Канад, Норвеги, Өмнөд Африк, АНУ гэх мэт) байгалийн баялгаа ухаалгаар удирдаад зогсохгүй эдийн засгаа төрөлжүүлэн тогтвортой өсөлтийг бий болгож, ард иргэдийнхээ ая тухтай, сайн сайхан амьдралын түвшнийг эрс дээшлүүлж чаджээ. Эдгээр улсын амжилт нь байгалийн баялгаас үүдэх эрсдэл хийгээд боломжийг бодитой үнэлэн хүлээн зөвшөөрч, нөхцөл байдалдаа таарсан тогтвортой бөгөөд зөв бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой.

Амжилттай хөгжиж буй улсын жишиг

Монгол улс байгалийн баялгаа түшиглэн эдийн засгаа хүчирхэгжүүлэх их аянд дөнгөж мордоод байна. Байгалийн баялагтай, түүнийгээ олборлон хөгжсөн бусад орны өнгөрсөн үеийн амжилт ололт, алдаа дутагдлаас суралцах бэлэн боломж бидний өмнө бий. Бусад улсын эдгээр туршлага нь бодлогын ямар замаар явахад ямар үр дүнд хүрдгийг толь мэт харуулна. Чили улс олон талаараа Монголд жишиг болно. Тус улс нь байгалийн баялгийн хараалаас зайлсхийж, ашигт малтмалаас хамаарах хамаарлаа бууруулж, эрдэс баялгаа тогтвортой үнэ цэнэ болгож чадсан цөөн улсын нэг. 50 жилийн өмнө өнөөдрийн дэлхий дээрх хамгийн том зэс үйлдвэрлэгч Чили цөөн хүн амтай, жижигхэн бөгөөд алслагдмал эдийн засагтай хэврэг улс байлаа. Түүнээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд Латин Америкийн хамгийн хурдан хөгжиж буй эдийн засаг болсон байна.

Зураг 27: Чили улс уул уурхайн салбартаа хувийн хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгосноор дэлхийн тэргүүлэх зэс үйлдвэрлэгч болов



Татаж авах

Эх үүсвэр: "Туркойз хилл ресурс" компани

“Монгол улс байгалийн баялгаа амжилттай удирдан хөгжиж буй бусад улсаас суралцах ёстой. Эдийн засгийн зөв бодлого, санхүүгийн ухаалаг удирдлагыг хэрэгжүүлбэл залуу бөгөөд хурдацтай өсөж буй Монголын уул уурхайн салбар хөгжлийнхөө дараагийн түвшинд гараад зогсохгүй үндэсний эдийн засгаа төрөлжүүлэх боломжтой юм”.

Чили улсын уул уурхайн амжилтын үндсэн шалтгаан нь хууль эрхзүйн орчин нь байсан юм. Хуулиараа Засгийн газрын үүргийг хөрөнгө оруулагч ба зохицуулагч гэж тодорхой ялгаж өгсөн. Урт хугацааны тогтвортой байдал, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын бага ачаалал, татвар хураах оновчтой систем зэргээр дамжуулан хувийн өмчийн оролцоог уул уурхайн салбарт нэмэгдүүлэн баталгаажуулснаар хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж чаджээ. Үр дүнд нь тус улсын уул уурхайн салбарын засаглалын стандарт нь олон улсын тавцанд жишиг болж, нээлттэй, ил тод байдлаараа дэлхийд тэргүүлж байна. Зэсийн үнийг тогтворжуулах сан байгуулснаар уул уурхайн бизнесийн мөчлөгийн хэлбэлзэл, үнийн огцом цочролоос улсын төсвөө хамгаалж, үүнтэй холбогдон гарах эдийн засгийн эрсдэлийг бууруулжээ. Уул уурхайн салбар амжилттай хөгжихийн хэрээр ард түмэн нь гадаадын хөрөнгө оруулалтыг аяндаа хүлээн зөвшөөрч эхэлсэн байдаг. Чили улс 1990 онд уул уурхайн салбартаа хувийн хөрөнгө оруулалтыг оруулж эхэлсэн нь эдийн засгийн хурдацтай хөгжлийнх нь суурь болсон юм.

ЭРДЭС БАЯЛАГ ДАНГААРАА ЭДИЙН ЗАСГИЙГ АМЖИЛТАД ХҮРГЭХ БАТАЛГАА ХЭЗЭЭ Ч БОЛДОГГҮЙ



Олон орон байгалийн баялгийн өгөөжөө бүрэн хүртэж чадаагүй

- > Ашигт малтмалын үнийн огцом өсөлт буурсны дараа ДНБ-ий өсөлт нь ашигт малтмалгүй улсынхаас ч удааширсан
- > Ашигт малтмалын салбар огцом өссөнөөр эдийн засгийн бусад салбарыг золиосонд гаргадаг
- > Ихэвчлэн ашигт малтмалаас олсон түр зуурын орлого бусад салбарт хөрөнгө оруулахын оронд буруу зарцуулагддаг

Хүчтэй, тогтвортой институци

Канад улс уул уурхайн хөрөнгө оруулалтын судалгаагаар байнга тэргүүлдэг


Бодлогын ойлгомжтой байдлын индекс



Гадаадын хөрөнгө оруулалт татах

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татсанаар Перу улсын уул уурхайн огцом өсөж, дэлхийн хоёр дахь том зэс үйлдвэрлэгч болсон


Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Эдийн засгийн солонгорол

Чилийн Засгийн газар эдийн засгаа хөгжүүлэхийн тулд уул уурхайн салбараас орж ирсэн ашгаараа уул уурхайн бус салбарт хөрөнгө оруулалт хийсэн

Зэсийн үйлдвэрлэл ба эдийн засгийн солонгорол



Эдийн засгийн муу бодлого ба институцийн чадамжаас хамааран байгалийн баялгаа үнэ цэнэ болгож чаддаггүй

- > Уул уурхайн салбарын огцом өсөлт нь эдийн засгийн эрүүл бүтцийг эвдэж, уул уурхайн бус салбарын өрсөлдөх чадварыг сулруулдаг
- > Дэлхийн зах зээлийн үнэ дээр суурилсан эрдэс баялгийн татвар нь үнийн өөрчлөлтөөс болж огцом хэлбэлздэг. Үүнээс болж улсын эдийн засгийн төлөвлөлт, санхүүгийн удирдлагыг хийхэд хүндрэл учирдаг.
- > Уул уурхайн баялагтай холбоотой бизнес бүлэглэлийн тэмцэл, улс төрийн фракц хоорондын тулаан зэрэг дотоод зөрчил, бодлого судалгааны хүрээлэнгийн сул чадавхи



Өөрсдийн ашигт малтмалын өгөөжийг бүрэн хүртэж чадаагүй олон орон бий. Харин Монгол Улс өөрийн амжилтын жорыг бичиж чадна. Ингэхдээ бусдын алдааг давталгүй, амжилтыг нь өөриймшүүлж уул уурхайн салбарын өгөөжийг эдийн засгийн тогтвортой хөгжлийн үнэ цэнэ болгох ёстой.



Бэрхшээлийг даван туулж гарсан олон улс байдаг


- > Хамгийн амжилттай нь шинэ хөрөнгө оруулалт татах нөхцөлийг байнга бүрдүүлдэг
- > Татварын системээр дамжуулан байгалийн баялгаас олох орлогоороо дараа үеийнхэндээ хуримтлал бий болгохоос гадна нийгэм болон эдийн засгийн дэд бүтцэд хөрөнгө оруулдаг
- > Эдгээр улсуудын эдийн засаг амжилттай хөгжихийн хэрээр ард иргэдийн амьдралын түвшин дээшилдэг

Баялгийг үнэ цэнэ болгох нь засаглалын чанартай шууд хамааралтай

- > Сангийн болон мөнгөний бодлогоор дамжуулан уул уурхайн мөчлөгийн хэлбэлзлийг тэнцвэржүүлдэг
- > Эдийн засгийн тогтвортой байдал нь уул уурхай болон бусад салбарт хөрөнгө оруулалт чухал
- > Эдийн засгийг солонгоруулах урт хугацааны стратегийг хэрэгжүүлэх



Норвегийн баялгийн сан



Орлогоо ирээдүйн үеийнхэнд хадгалдаг

Норвегийн баялгийн сан газрын тосны орлогыг удирдан ирээдүйн үеийнхэнд хадгалдаг. Уг сангийн үнэлгээ 1 их наяд ам.доллар даваад байна.


Ботсвана №1

Африкийн №1 хөрөнгө оруулах улс



Үйлдвэрлэлийн иж бүрэн процесс

Ботсванийн эрдэс боловсруулах үйлдвэрлэл нь тогтвортой хөрөнгө оруулалтын нөхцөлийг бүрдүүлсэн



Уул уурхайн кластер

Баруун Австрали эрдэс зүйгээ Уурхай хоорондын дундын сүлжээ байгуулах болон дэд бүтцэд хөрөнгө оруулсан

ДҮГНЭЛТ

Монгол улс өнөөдөр салаа замын уулзвар дээр байна. Зөвлөлт Холбоот Улс нуран унаж, Монголын социалист туршилт төгсгөл болсон. Ардчилал шинэ өөдрөг үзэл санаа авчирсан бөгөөд бахдам, арвин соёлтой нийгэм маань эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийг сонголтгүй угтан авсан. Энэ өөрчлөлтийн гол цөмд онгон байгалийн эрдэс баялгийн үрээр бий болох эдийн засгийн чадавх нуугдаж байсан юм. Байгалийн эрдэс баялгийг олборлох нь боломж завшаан авчрах төдийгүй бас зовлон бэрхшээл дагуулдаг. Тогтмол хянаж, зохистой удирдахгүй бол ашигт малтмалаас олох орлого нь маш хувирамтгай, макро эдийн засгийн гажуудал үүсгэх, орон нутагт дарамт, стресс болох талтай байдаг. Эдгээр бүх сорилттой нүүр тулахаар хөгжлийн бартаат хурдны зам руу Монгол Улс нэгэнтээ оржээ. Хөгжил өөд тэмүүлэх аялал амаргүй байгаа хэдий ч эдийн засгаа тогтворжуулан сэргээж чадаад байна. Энэ бол дөнгөж эхлэл бөгөөд одоо хүртэл эдийн засгаа хөгжүүлэх олон боломжоо хараахан бүрэн ашиглаж эхлээгүй л байна.

Монгол Улсын компани “Оюу толгой” нь эрдэс баялгийн хөрөнгө оруулалтын жишиг болсон уул уурхайн хамгийн том компани юм. Энэ төслийн бүтээн байгуулалтын эхний үе шат амжилттай дуусч үйл ажиллагаа нь жигдэрсэн бөгөөд дэлхийд цөөхөн байдаг гүний уурхайн ярвигтай төслийн бүтээн байгуулалтын ажил ид өрнөж байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнхээ оргил үед энэ уурхай Монгол Улсын эдийн засгийн үндсэн хөдөлгүүр болж дэлхийн зэс үйлдвэрлэгч топ 10 улсын нэг болно. Аварга том мөртлөө нарийн түвэгтэй нөхцөл байдал нь техникийн ур чадвар, мэдлэг туршлага, гадаадын хөрөнгө оруулагчдын санхүүжилт шаардах бөгөөд аль хэдийнэ 11.8 тэрбум ам.долларын санхүүжилт авахаар баталгаажсан нь Монгол Улсын эдийн засгийн хэмжээтэй яг тэнцэж байна. Нэмж хэлэхэд, байгалийн баялгийн эзэн, хууль эрхзүйн орчны зохицуулагч гэдэг хоёр үүргээсээ гадна Монгол Улсын Засгийн газар уг төсөлд хувьцаа эзэмшигч хэлбэрээр давхар оролцсон. Энэ хувь эзэмшлийг баталгаажуулахын тулд хөрөнгө оруулагчид Монголын талд ногдох эзэмшлийн хувийг урьдчилж санхүүжүүлсэн юм.

Ашигт малтмалын өмчлөгч, хууль эрхзүйн орчны зохицуулагч, хувьцаа эзэмшигч гэсэн гурван үүрэгтэйгээр энэ төсөлд оролцож буй Монгол Улсын Засгийн газар нь үүрэг бүрээсээ ялгаатай өгөөжийг “Оюу толгой” төслөөс хүртэж байна. Тухайлбал, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, шимтгэл болон ногдол ашиг хэлбэрээр өгөөж хүртэнэ. Энэ бүх эдийн засгийн өгөөжийн нийлбэр нь “Оюу толгой” төслийн нийт цэвэр мөнгөн урсгалын 50 гаруй хувийг эзэлж байна. Засгийн газар өөрийн эзэмшлийн хувиа ямар нэг урьдчилгаа хөрөнгө оруулалгүй, эрсдэлгүйгээр авч баталгаажуулсан бөгөөд үүний санхүүгийн баталгааг хөрөнгө оруулагчид гаргасан билээ. “Оюу толгой” компанийн эдийн засгийн ач холбогдлыг дангаар нь тооцвол Монголын эдийн засагт оруулж буй өргөн цараатай нөлөөг нь орхигдуулдаг юм. Монгол Улсын хүртэх нийт өгөөжийг дотоодын аж ахуйн нэгжүүдтэй жил бүр хийдэг 300 сая ам.долларын гэрээ, 2,500 ажлын байр, бусад гэрээт компаниуд, орон нутгийн хөгжил, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, сургалт болоод технологи дамжуулалтын зэрэгцээ Засгийн газар, ажиллах хүч болон бизнес нь эргээд олсон орлогоо дотоодын бизнесийг дэмжин зарцуулагдаж буйн хэрэглээний үржүүлэгчийн нөлөөтэй нь хамтатган тооцож байж энэхүү төслийн бодит үнэ цэнийг мэднэ.

Ийм том хэмжээний төсөл ямар нэг зөрчил маргаангүй явах нь ховор байдаг. Гэсэн ч “Оюу толгой” хөрөнгө оруулалтын хэмжээ, төслийн хугацаа, хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлээр өмнийн говьд уул уурхайн жишиг төв болох нь гарцаагүй. Уул уурхайн салбарын хамтын үнэ цэнийг бий болгож чадсан энэхүү төсөл Монгол Улсын түүхэндээ татсан хөрөнгө оруулалтын оргил болж түүхэнд бичигдээд байна. Олон орон өөрийн эрдэс баялгийг тогтвортой үнэ цэнэ болгож чадаагүй бүтэлгүйтсэн байхад цөөнгүй улс орон эрдсийн нөөцөө ухаалгаар удирдан урт хугацааны эдийн засгийн өсөлт, хөгжлийг бий болгожээ. Монгол Улсад тэрхүү амжилтыг давтах бүх өгөгдөл нь бий. Хөрсөн доорх байгалийн баялгаа газар дээрх эдийн засгийн бодит үнэ цэнэ болгон эдийн засгаа солонгоруулан хөгжүүлэх боломж нээлттэй хэвээр байна.

“ОЮУ ТОЛГОЙ”

Түүхийн товчоон

1



Эдийн засгийн шилжилт

Монгол Улсын байгалийн нөөцдөө түшиглэн хийж буй эдийн засгийн шилжилт нь хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, улсын тогтвортой өсөлтийг хангах бүрэн боломжтой. Эдийн засгийн агуулгаараа уул уурхай нь бусад аж үйлдвэрийн салбараас ялгагдах шинж чанартай. Энэ шинж чанарыг сайтар судалж, ойлгох нь Монгол Улсын эдийн засаг өсөж томроход ихээхэн ач тустай. Ингэснээр уул уурхайгаас хүртэх өгөөжийг хамгийн дээд түвшинд хүргэж, учирч болох эрсдэлийг бүрэн удирдах боломж бий болно.

Уул уурхайн хүнд
жингийн тоглогч



Түүхэн хөрөнгө оруулалт

Монгол Улсад үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт орж ирсэн тэр үе бол дэлхийн даяар улс дамнасан хөрөнгө оруулалт царцсан, томоохон санхүүжүүлэгчид эрсдэлээс зайлсхийн нуугдсан зогсонги он жилүүд байсан юм. Монгол Улс цаашдаа өрсөлдөх чадвар сайтай байж, эх орондоо хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн татахын тулд хөрөнгө оруулахад таатай, тогтвортой орчныг үүсгэх учиртай.

2



Нээлт – энэ бол дөнгөж эхлэл

Хайгуулын ажлаас уурхай болон хөгжих магадлал мянгад нэг удаа гэдэг багцаа бий. Эрдэс баялгийн судалгаа хэчнээн сайн байгаад дангаараа амжилтад хүрдэггүй. Нээлтийн дараа чамгүй өндөр үнэ өртөг, эрсдэл бүхий үйл явцуудыг давж байж уурхайг байгуулдаг. “Оюу толгой” компани ч мөн үүнийг тойроогүй бөгөөд ихээхэн чармайж энэ бүх хүндрэлүүдийг даван туулсаар ирсэн юм.

Дэлхийн энтэй
уурхай



Техникийн ярвигтай асуудал

Энэ нүсэр том төслийн үйл ажиллагааг сүүлийн үеийн техник, өндөр технологийн хүчээр л хангах боломжтой. Ялангуяа блокчлон олборлох арга нь нэлээд нарийн төвөгтэй бөгөөд дэлхийн цөөн тооны уурхайд л амжилттай ашиглаж байгаа. Түүнчлэн ашигт малтмалын нөөцийг хамгийн үр ашигтай ашиглахад уурхайн удирдлага, хөрөнгө оруулагчдын үр чадвараас маш их зүйл шалтгаалдаг.

3



Засгийн газарт ирэх өгөөж

Нийт төслийн хугацаанд Монголын Засгийн газарт ирэх өгөөж нь төрөл бүрийн урсгалаар ирдэг. Энэ өгөөжийн хэмжээ бусад хөрөнгө оруулагчдын авах ашгийн нийлбэрээс ч илүү гарна. Засгийн газар төсөл дэх өөрийн оролцоог ТУЗ-д байх өөрийн төлөөлөгчөөр дамжуулан хангадаг бөгөөд компанийн стратегийг тодорхойлоход оролцдог. Түүнчлэн Монгол Улсын засгийн газар өөрийн хувь эзэмшилд ногдох урьдчилсан хөрөнгө оруулалтыг гаргах хариуцлага үүрэггүй болохыг дурдах нь зүйтэй.

Эдийн засгийн
нөлөө, үнэ цэнэ



Ашгийн цаадах өгөөжүүд

“Оюу толгой” төслийн эдийн засгийн ач холбогдлыг үнэлэхдээ зөвхөн хөрөнгө оруулагчид болон Засгийн газрын хоорондох хувь эзэмшлийн хүрээнд ойлговол нийт өгөөжийн өчүүхэн хэсгийг харж байна гэсэн үг. Монгол Улсад орж буй нийт өгөөж, үнэ цэнэ нь зөвхөн татвар, хураамж, төлбөр, ногдол ашгаар хязгаарлагдахгүй, харин цалин хөлс, ханган нийлүүлэгчдийн төлбөрүүд, нийгмийн хөрөнгө оруулалтууд болон эдийн засгийн үржүүлэгч хүчин зүйлсээр тодорхойлогдох учиртай.

4



Нэг уурхайгаар тогтохгүй

Оюу толгойн орд нь нөөцийн хэмжээ, үзүүлэлтээрээ өмнийн говьд байрлах дэлхийн жишиг уурхайн кластер болж, гадаадаас улам их хөрөнгө оруулалт татах бүрэн боломжтой. Дундын дэд бүтэц ашиглан зэргэлдээх ордуудыг нэгэн зэрэг хөгжүүлэх нь орд бүрийг тус тусад нь ашиглахаас хавьгүй үр ашигтай байдаг. Алсын хараа, тогтвортой бодлого нь энэ бүхнийг гүйцэлдүүлэх гол хүчин зүйлс болно.

Амжилтын суурь



Амжилттай засаглал

Эрдэс баялгийн нөөц нь Монголын эдийн засаг хөгжих замналын үндэс болно. Хэдийгээр ашигт малтмалын нөөц ихтэй улс бүхэн баялгаа бодит үр ашиг болгож чаддаггүй ч Монгол Улс амжилттай хэрэгжсэн төслүүдийг судлах боломжтой. Зөв бодлого, орлогын ухаалаг зарцуулалтын удирдлагыг хэрэгжүүлснээр байгалийн баялгаар арвин, харьцангуй залуу эдийн засагтай Монгол Улс эдийн засгаа хөгжүүлж, төрөлжүүлж чадна.

